**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23117
Утас/Факс: (976) 7056 2412
Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn

2026.01.27 № 9/204

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар хүргүүлэв.

Цахим мэдээллийн сан www.unelgee.gov.mn-д тайланг баталгаажуулав.

ДАРГА А.ЖАРГАЛСАЙХАН

2326130259

[illegible]

[illegible] www.unelgee.gov.mn [illegible]

[illegible]

[illegible]


[illegible] : www.khentii.mn

[illegible] : infoazdtg@khentii.gov.mn

[illegible] · 23117 · [illegible] : (976) 70562412 ·

[illegible] 1 · [illegible]

# ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
# 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэтгэлийн хувь | ХШҮХ үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | |
| **НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| 1.1 БҮСИЙН ХӨГЖИЛ | | | | | | | | |
| 1.1.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг дэмжинэ. | | | | | | | | |
| 1.1.1.1 "Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс" болох суурь дэд бүтцийг байгуулна. | | | | | | | | |
| 1 | 1.1.1.1.1 Өндөрхаан, Дэлүүн болдог олон улсын нисэх буудлуудыг ашиглалтад оруулах | 5055.0 | Гүйцэтгэлийн хувиар | Өндөрхаан нисэх буудал 95%, Дэлүүн болдог нисэх буудал 65% | 100% | "Өндөрхаан" нисэх буудал 2025 оны 7 дугаар сарын 04-ний өдөр бүрэн (100%) ашиглалтад орж, нээлтээ хийсэн.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дадал суманд баригдаж буй "Дэлүүн болдог" нисэх буудлын барилгын ажлыг "Барилга элч" ХХК гүйцэтгэж дууссан бөгөөд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлт өгсөн байна. | 100 | 100 |
| 2 | 1.1.1.1.2 Аялал жуулчлалын гол бүсүүдийг хатуу хучилттай авто замаар холбож, дэд бүтцийг сайжруулах | 881,513.6 | Тухайн жилд батлагдсан санхүүжилтийн гүйцэтгэлийн хувиар | 100% | 100% | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Аялал жуулчлалын гол бүсүүдийг хатуу хучилттай авто замаар холбох 687.8 тэрбум төгрөгийн төсөвтэй, 17 багц, төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа. Тус ажлууд нь энэ жилийн санхүүжилтэд гүйцэтгэх ажлаа 100% хийж гүйцэтгэсэн. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | 1.1.1.1.3 Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн төв байгуулах хувийн хэвшил, хоршоодыг дэмжих | | Дэмжлэг үзүүлсэн үйлдвэрлэл, үйлчилгээний тоогоор | - | 1 | Зүүн бүсийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний цогцолбор бүхий үйлдвэр технологийн парк байгуулах 10га газрын асуудлыг Хэрлэн сумын 2026 оны Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд оруулахаар байршлыг тодорхойлон кадастрын зургийг бэлэн болгосон. Хэрлэн сумын ИТХ 12 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж газрын шийдвэр гарна. Төслийн ТЭЗҮ боловсруулагдаж БХТөвийн мэргэжлийн зөвлөлөөс дүгнэлт гаргуулж, аймгийн удирдлага болон холбогдох байгууллагуудаас санал авсан. Одоо БХТөвийн магадлалаар орохоор хүргэгдээд байна. | 30 | 0 |
| 4 | 1.1.1.1.4 Бүсийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах | 80.0 | хэлэлцүүлэг зөвлөгөөн арга хэмжээний тоогоор | Хоршоочдын, тариаланчдын бүсийн зөвлөгөөнүүд зохион байгуулсан, бүсчилсэн хөгжлийн улсын чуулганд оролцсон. | 2 | "Бүсчилсэн хөгжил-тогтвортой газар тариалан 2025" нэгдсэн зөвлөгөөн, Зүүн бүсийн нийтийн ахуй үйлчилгээний анхдугаар чуулган, хэлэлцүүлэг, "Зүүн бүсийн хариуцлагатай уул уурхай" зөвлөгөөнийг зохион байгуулж, 2025 оны 09 дүгээр сарын 11-12 -ны хооронд Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгээс Minepro 2025 экспотой хамтатган бүсүүдийн хэлэлцүүлгийг зохион байгуулж зүүн бүсийн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжилд тулгамдаж буй асуудал цаашдын хөгжлийн гарцын талаар "Зүүн бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр"-ийг танилцуулах үйл ажиллагаанд хамтран ажиллалаа. | | |
| 1.1.1.2 "Өндөрхаан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-нд тодотгол хийж, үйлдвэрлэл, үйлчилгээ, тээвэр, логистик, дэд бүтцийн хөгжил бүхий иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлсэн "Чингис хот"-ыг хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 5 | 1.1.1.2.1 Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлтийг хийх | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэрэгжилтийн хувиар | - | 40 | Чингис хотын хэмжээнд 5 чиглэлд, 21 автобусны буудлаар өглөө 3, өдөр 3, орой 3 тойрог маршрутаар 6 цахилгаан автобус, 25 хүний суудалтай 1 автобусаар иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлж байсныг парк шинэчлэлтийн ажлын хүрээнд 39.0 сая төгрөгийн хөрөнгөөр 6 чиглэлд, 24 автобусны буудал болгон нэмэгдүүлж, 6 цахилгаан автобусны баттерейг бүрэн шинэчилж, шаардлагатай засвар үйлчилгээг хийснээр нийтийн тээврийн хэвийн үйл ажиллагааг хангаад байна. | 100 | 0 |
| 6 | 1.1.1.2.2 Чингис хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор агаарын чанарын 1, 2-р бүсэд мөрдөх журмын хэрэгжилтийг хангах | | Хэрэгжилтийн хувиар | 80% | 85% | Чингис хотын агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн бүсэд мөрдөх журмыг боловсруулан, Захиргааны ерөнхий хуулийн дагуу зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг, нөлөөллийн шинжилгээ, тайлан мэдээний хамт БОУАӨЯаманд хүргүүлж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, аймгийн Засаг даргын | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтарсан шийдвэр A/830, A/583 дугаартай тушаал/захирамжаар батлуулсан. Журамд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх 18, төрийн байгууллагуудын дагаж мөрдөх 9 эрх, үүргийг тусгасан ба хариуцсан байгууллагуудад чиглэл өгч хэрэгжилтийг 90 хувьтай хангуулан ажиллаж байна. | | |
| 7 | 1.1.1.2.3 Чингис хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгч иргэдэд ая тухтай үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж "Хэрэглэгчдэд үйлчлэх төв"-ийн барилгыг ашиглалтад оруулах. | 847.1 | Гүйцэтгэлийн хувиар | Зураг төсөл, ТЭЗҮ хийгдсэн. | 30 | Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 3.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилга (Хэнтий ЦТСС)" төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 45 хувьтай үргэлжилж байна. | 100 | 100 |
| 8 | 1.1.1.2.4 Иргэдийн амьдрах тав тухтай эко орчин бүрдүүлсэн, ногоон худалдан авалтыг дэмжих, цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. | | Тухайн жилд батлагдсан санхүүжилтийн гүйцэтгэлийн хувиар | 100% | 100% | Аймгийн 2025 оны ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар иргэдэд үйлчлэх "Хурдан" төвийн нарны толь суулгах, цахилгаан машины цэнэглэгч суурилуулах" төсөл хэрэгжиж ашиглалтад оруулсан. Иргэдийн амьдрах тав тухтай эко орчин бүрдүүлэх, цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор ОНХС-ийн хөрөнгө оруулалтын 5.8 тэрбум төгрөгийн төсөвтэй 9 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж тус онд санхүүжих дүнд тусгагдсан ажлууд 100% гүйцэтгэлтэй хийгдээд байна. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.1.3. Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлд түшиглэсэн сум хөгжүүлнэ | | | | | | | | |
| 9 | 1.1.1.3.1 Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй сум суурин газрын төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх | 636,0 | Сумын тоогоор | - | 6 | 2025 онд 16 сум, 2 тосгон Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулахаар аймгийн болон сумын орон нутгийн төсөвт нийт 2.2 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар Өмнөдэлгэр, Галшар, Баян-Овоо, Цэнхэрмандал, Дархан, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Батноров, Баянмөнх, Биндэр, Баян-Адарга, Норовлин, Дадал, Мөрөн 14 сумдын гүйцэтгэгч шалгарч, гэрээ хийгдсэн ба Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж дундын болон эцсийн тайлангийн шатандаа ажил үргэлжилж байна. | 100 | 0 |
| 10 | 1.1.1.3.2 Сумд доторх хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх | | Авто зам нэмэгдсэн сумдын тоо | автозам 6 | 3 (Биндэр, Баян-Адарга, Хэрлэн) | 2025 оны УТХОруулалтаар "Хэнтий аймаг, Биндэр сум, сумын төвийн 4.26 км хатуу хучилттай авто замын ажил", "Хэнтий аймаг, Хэрлэн сум, 1 дүгээр багийн дундуур тавигдах 0.58 км авто замын шинэчлэлтийн ажил", "Хэнтий аймаг, Баян-Адарга сум, сумын төвийн гудамж 2.84 км авто замын ажил" хэрэгжихээр батлагдсанаар Биндэр сумын төвийн 4.26 км хатуу хучилттай авто замын ажил, Баян-Адарга сумын төвийн гудамж 2.84 км авто | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зам төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр "Их хайрханы Харгуй" ХХК шалгарч энэ онд санхүүжих дүнд тусгагдсан ажлаа 100% хийж гүйцэтгээд байна. | | |
| 11 | 1.1.1.3.3 Сумдын гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх | 782.0 | Гэрэлтүүлэг нэмэгдсэн сумдын тоо | гэрэлтүүлэг 4 | 3 | Орон нутгийн төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Жаргалтхаан, Баян-Овоо, Баян-Адарга, Хэрлэн сум болон Бэрх тосгонд гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх 5 төсөл арга хэмжээ хэрэгжиж тус онд санхүүжих дүнд тусгагдсан ажлаа 100% хийж гүйцэтгэсэн. | 100 | 100 |
| 12 | 1.1.1.3.4 Сумын төвийн цахилгаан түгээх сүлжээ шинэчлэх, шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангана. | 3039.8 | Сумын тоо | 6 сумын цахилгаан түгээх сүлжээг шинэчилсэн. | 5 | Аймгийн 2025 оны төсөвт Хэрлэн, Баянмөнх, Баян-Адарга, Норовлин, Батноров, Дадал 6 суманд цахилгаан түгээх сүлжээ шинэчлэх, шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах 4.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээ батлагдаж тус онд санхүүжих дүнд тусгагдсан ажлууд 100% гүйцэтгэлтэй байна. | 100 | 100 |
| **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| 2.1 ГЭР БҮЛ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХҮН АМ | | | | | | | | |
| **2.1.1. Гэр бүлийн болон нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулах, өсвөр үе залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 13 | 2.1.1.1 Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын "Ирээдүйн ээзд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | * | Хэрэгжилтийн хувиар | - | Хөтөлбөр батлуулахтөл өвлөг -өөний хэрэгжилт 90- | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 5 дугаар хуралдааны 9 дүгээр тогтоолоор Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын салбар дундын | 91,5 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ээс дээш хувь байх | “Ирээдүйн ээзд” хөтөлбөрийг батлуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх 10 зорилт бүхий төлөвлөгөө боловсруулж, 91,5 хувьтай хэрэгжүүлсэн. | | |
| 14 | 2.1.1.1.1 Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүсчлэн сумдад байгуулах | 60.0 | Цогц үйлчилгээний төвийн тоо, зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | - | Биндэр, Бор-Өндөр сумдад бүсийн гэр бүлийн хөгжлийн үйлчилгээний төв байгуулсан байна. | Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг Батноров, Бор-Өндөр сумдад байгуулж, төвөөр дамжуулан нийт 4 нөлөөллийн ажил, 3 аян зохион байгуулж, 2595 өрхийг хамруулсан. | 100 | 100 |
| 15 | 2.1.1.1.2 Гэр бүлийн хөгжлийн төвүүдээр дамжуулан гэр бүлд тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн хөгжлийн үйлчилгээг үзүүлэх | 10.0 | Хувиар | Урьдчилан сэргийлэх 5 нөлөөллийн ажил зохион байгуулж,1362 өрх буюу 30 хувь, зорилтод бүлгийн 11 өрх буюу 3 хувьд цогц үйлчилгээ үйлчилгээ үзүүлсэн. | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан бүсийн нийт өрхийн 30 хувьд урьдчилан сэргийлэх үйлчилгээ, зорилтот өрхийн 5 хувьд цогц үйлчилгээ үзүүлсэн байна. | Урьдчилан сэргийлэх чиглэлээр ганцаарчилсан зөвлөгөөнд 40, бүлгийн зөвлөгөөнд 107, лекцээр 677, нөлөөллийн үйл ажиллагаанд 619, сургалтад 803, давхардсан тоогоор нийт 2246 өрхийн гишүүдийг хамруулж, бүсийн нийт өрхийн 30 хувьд урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлж ажиллахаас жилийн эцсийн байдлаар бүсийн нийт өрхийн 108,9 хувьд нь урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлсэн байна. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр дамжуулан Монгол-Өрх сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран Батноров, Галшар, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Норовлин, Хэрлэн сумын эрсдэлт | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нөхцөл дэх 204 өрхөөс, 150 өрхийн 239 хүүхэд, насанд хүрэгчдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн нь эрсдэлт өрхийн 73,5 хувийг эзэлж байна. | | |
| 16 | 2.1.1.1.3 Хүүхэд, гэр бүлийн өмнө үүрэг хүлээгчдийг чадавхжуулах, дэмжих | 10.0 | Хувиар | 6 удаагийн сургалт, 1 арга хэмжээнд давхардсан тоогоор 456 үүрэг хүлээгч буюу нийт үүрэг хүлээгчдийн 66 хувийг хамруулсан. | Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан болон хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн 70 хувийг сургалтад хамруулсан байна. | Хүүхэд, гэр бүлийн өмнө үүрэг хүлээгчдийг чадавхжуулах сургалтыг танхимаар 7 удаа, цахимаар 1 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 355 үүрэг хүлээгчид буюу 91 хувийг чадавхжуулан сургалтад хамруулсан. | 100 | 100 |
| 17 | 2.1.1.1.4 Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж, хөгжлийг дэмжих ажлыг олон нийтийн оролцоотой хэрэгжүүлэх | ХГБХХГ-80.0 ИШО-150.0 | Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан хүүхдийн тоо, хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлага мэдээлэлд холбогдох хүүхдүүдэд шаардлагатай үйлчилгээг үзүүлсэн хувь, хөгжлийн үйлчилгээнд | Урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 үйл ажиллагаанд давхардсан тоогоор 14162 хүүхэд хамруулсан. Хүүхдийн эрхийн зөрчлийн 118 дуудлагад хамаарах 197 хүүхдэд 987 удаагийн хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн. Хөгжлийн үйлчилгээнд | Урьдчилан сэргийлэх чиглэлээр 14-аас доошгүй үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 14000-аас дээш хүүхэд хамруулна. Хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлага мэдээлэлд холбогдох хүүхдүүд эд шаардлагатай үйлчилгээг 90- | Урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 14 үйл ажиллагаанд давхардсан тоогоор 11636 хүүхэд, 2851 насанд хүрэгч нийт 14487 хүн хамруулсан.<br>Хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлага мэдээлэл нийт 235 бүртгэгдэж, тус дуудлага мэдээлэлд холбогдох 509 хүүхдэд, 1943 удаагийн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, шаардлагатай үйлчилгээг 100 хувь хүргэж ажилласан.<br>Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх хөгжлийн төв болон Ид шидийн орон хүүхэд хөгжлийн төвийн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамрагдсан хүүхдийн тоо | давхардсан тоогоор 7800 хүүхэд хамруулсан. | ээс дээш хувьд хүргэсэн байна. Хөгжлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 8000-аас дээш хүүхэд хамруулна | нийт 13 төрлийн дугуйланд давхардсан тоогоор 3414 хүүхэд, 18 сум, 4 тосгонд 7164 хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан ба нийт хөгжлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 14774 хүүхэд хамруулсан. | | |
| **2.1.1.2 Засгийн газраас хэрэгжүүлж буй өсвөр үе, залуучуудын хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| 18 | 2.1.1.2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангах | 20.0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 90-ээс дээш хувьтай хангана | 2025 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх газрыг нэмэгдүүлэх зорилгоор "Шэйр оффис" буюу Залуучууд төвийг 13.0 сая төгрөгийн өртгөөр аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр тохижуулан 2025 оны 03 сарын 29-ний өдөр нээлтээ хийсэн. Энэхүү залуучууд төвийн үйл ажиллагаанд зориулж "Мэдлэгийн хүч" номын хандивын аяныг өрнүүлж төвийн 10 байгууллага, 18 сум нэгдэж нийт 644 ном хандивласныг оффист байрлуулаад байна.<br>Хэнтий аймгийн 18 сум 3 тосгодын залуучуудын 14 салбар зөвлөлтэй хамтран ажиллаж урлаг спортын цогц арга хэмжээ, сайн | 90 | 0 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дурын ажил зэрэг 45 үйл ажиллагаа зохион байгуулж нийт 3880 залуучуудыг хамруулсан. | | |
| 19 | 2.1.1.2.2 Залуучуудыг чадавхжуулах сургалт, өдөрлөг зохион байгуулах | 10.0 | Хамрагдсан залуучуудын тоо | Өдөрлөгт 462 залуучууд хамрагдсан | Сургалт өдөрлөгт 500-с доошгүй залуучуудыг хамруулна. | Хэнтий аймгийн 15-34 насны өсвөр үе, залуучуудыг чадавхжуулах зорилгоор нийт 7 төрлийн сургалт, өдөрлөгийг төрийн болон төрийн бус 7 байгууллагатай хамтран зохион байгуулж 730 гаруй залуучуудыг хамруулсан. Үүнд: Монголын аялал жуулчлалын холбоотой хамтран нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын “100 хөтөч” бэлтгэх сургалтад 100 залуу, аймгийн Политехникийн коллежтой хамтран "Эсгий урлал"-ын сургалтад 30 залуу, “Бидний бахархал” төслийн зохицуулагч Х.Эрдэнэпил болон АЗДТГ-ын Цэргийн штабын хэлтэстэй хамтран “Эх оронч 10000” сургалтад 250 ахлах ангийн суралцагчид , Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар болон Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 5 компанитай хамтран залуу төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор “Залуучуудыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн”-ий үеэр "Хувь хүний хөгжил, | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | манлайлал", "ICO чанарын менежмент", "Ажил амьдралын тэнцвэрт байдал" сэдэвт сургалтад 270 залуу, Өлзийт тосгоноос хамтран зохион байгуулсан "Аз жаргалтай гэр бүлийн 4 нууц" сэдэвт сургалтад 25 гэр бүл, Хэрлэн сумын ЗДТГ-аас залуу малчдад зориулсан сургалтад 30 залуу өрхийг хамруулсан байна. | | |
| **2.1.1.3 Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ** | | | | | | | | |
| 20 | 2.1.1.3.1 Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлүүдийн туршлага судлах уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах | 10.0 | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо хамрагдсан залуучуудын тоо | Залуучуудын чуулга уулзалтад 100 залуу оролцсон. | Чуулга уулзалтад 180 залуу оролцсон байна. | Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар, Соёл, урлаг , аялал жуулчлал, залуучуудын газар "Монгол донж" төрийн бус байгууллагатай хамтран залуучуудад зориулсан "Chinggis City-2025" соёлын фестивалийг 2025 оны 06 дугаар сарын 27,28-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус өдрүүдэд залуучуудад зориулан 8 төрлийн арга хэмжээ зохион байгуулагдаж Хэнтий аймгийн залуучуудаас гадна Улаанбаатар хот, Дорнод, Сүхбаатар аймгаас нийт давхардсан тоогоор 15868 гаруй залуучууд оролцсон. | 100 | 100.00 |
| **2.1.2.1 Нийгмийн халамжийн зорилтот өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулна** | | | | | | | | |
| 21 | 2.1.2.1.1 Зорилтот өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг чиг баримжаа олгох | 375.0 мян төг | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо, | - | 50 иргэнийг чиг баримжаа олгох | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг зорилтот бүлгийн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сургалтад хамруулж, байнгын болон түр ажлын байранд зуучлах | | ажилд зуучлагдсан иргэдийн тоо | | сургалтад хамруулж, 30 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан байна. | хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэх , аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох дэмжих зорилгоор 78 иргэнийг Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалт болон хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтад хамруулан 43 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан. | | |
| **2.1.2.2 Хувийн хэвшил, ТББ- ын оролцоотой (ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй) иргэдийг дэмжиж ажиллана.** | | | | | | | | |
| 22 | 2.1.2.2.1 Төрийн бус байгууллагуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт, нөлөөллийн ажил, тэмдэглэлт өдөр (эрхийг хамгаалах өдөр, цагаан таягтаны өдөр,ахмадын баяр) | 35.0 | Хамрагдсан иргэдийн тоо, зохион байгуулагдсан ажлын тоо | 3 удаагийн арга хэмжээнд (цагаан таягтаны өдөр, ахмадын өдөр, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөр) 1056 иргэн хамрагдсан байна. | Төрийн бус байгууллагуудтай хамтран ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт, нөлөөллийн ажил, тэмдэглэлт өдөрт 1200 иргэнийг хамруулан 5 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг зорилтот бүлгийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэх , аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох дэмжих зорилгоор 78 иргэнийг Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалт болон хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтад хамруулан 43 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан. | 100 | 100.00 |
| 23 | 2.1.2.2.2 Төрийн бус байгууллагуудтай хамтран ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд | 8.0 | Тэмцээн уралдаанд оролцсон хөгжлийн | Улсын болон орон нутгийн 4 удаагийн тэмцээн | Улсын болон орон нутгийн 4 удаагийн тэмцээн | Параволейбол, Хонхот бөмбөг, Пара Бочи, Монгол Абилимп-2025 зэрэг улсын болон орон нутгийн 5 | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зориулсан үйлчилгээг үзүүлэх | | бэрхшээлтэй иргэдийн тоо/ | уралдаанд 72 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан | уралдаанд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй 80 иргэнийг хамруулна. | удаагийн тэмцээн уралдаанд хөгжлийн бэрхшээлтэй 90 иргэнийг амжилттай хамруулсан. Мөн Монголын бүх ард түмний спортын XVI дугаар наадмын ХБИргэдийн төрөлд 5 төрлөөр амжилттай оролцож 6 алт, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр Хэнтий аймаг 3 дугаар байр эзэлсэн. | | |
| **2.1.2.3 Төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан байнгын болон түр ажлын байрыг нэмэгдүүлнэ** | | | | | | | | |
| 24 | 2.1.2.3.1 Ажилд зуучлах үйлчилгээ | | Ажилд зуучилсан хүний тоо | 1012 иргэнийг ажлын байранд зуучилсан. | 1200 иргэнийг ажилд зуучилсан байна. | Ажил олгогчдоос ирүүлсэн сул чөлөөтэй ажлын байрны захиалгын дагуу ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй, ажил олоход хүндрэлтэй 1205 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан. | 100 | 100.00 |
| 25 | 2.1.2.3.2 Шинэ ажлын байр | | Шинээр бий болсон ажлын байрны тоо | 673 шинэ ажлын байр бүртгэсэн. | 800 шинэ ажлын байр бий болно . | Аймгийн хэмжээнд барилга, уул уурхай, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэрийн салбар болон бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хүрээнд шинээр бий болсон 880 ажлын байрыг бүртгэн авч хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн Ejob цахим системд шивж оруулсан. | 100 | 100.00 |
| **2.1.2.4 Ажил хайгч, ажилгүй иргэнийг ажилд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ** | | | | | | | | |
| 26 | 2.1.2.4.1 . Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа | 20.0 | Хөдөлмөрт бэлтгэх | Хөдөлмөрт бэлтгэх | Хөдөлмөрт бэлтгэх | Хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын болон аж ахуй | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сургалтад хамрагдсан хүний тоо | сургалтын үйл ажиллагаанд 313 иргэнийг хамруулж, 19.4 сая төгрөг зарцуулсан | сургалтад 300 иргэнийг хамруулсан байна. | эрхлэлтийн сургалтыг "Мэргэшсэн мэргэжил сургалтын төв" НҮТББ, "Эм Эс девелопмент консалтинк" ТББ-уудтай гэрээлэн хийж, тус сургалтад 480 иргэн хамрагдаж 19.590.000 төгрөгийг зарцуулсан. | | |
| 27 | 2.1.2.4.2 Ажил хөдөлмөр эрхлээгүй эмэгтэйчүүдийг мэргэжлийн ур чадвар нэмэгдүүлэх болон цахим ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулж, Төр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажлын байранд зуучлах | 3.7 | Сургалтад хамрагдсан хүний тоо, ажлын байртай болсон хүний тоо | Хувь хүний хөгжил, харилцаа ур чадвар дээшлүүлэх болон цахим ур чадвар, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтад 17 эмэгтэйчүүдийг хамруулж, 3.7 сая төгрөг зарцуулсан | Хувь хүний хөгжил, харилцаа ур чадвар дээшлүүлэх болон цахим ур чадвар, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх сургалтад 17 эмэгтэйчүүдийг хамруулсан байна | Ажил хөдөлмөр эрхлээгүй 14 эмэгтэйчүүдийг мэргэжил олгох няравын сургалтад , хөгжлийн бэрхшээлтэй 7 эмэгтэйчүүдийг гар урлалын сургалтад хамруулан 3.444.000 төгрөгийг зарцуулсан. | 100 | 100.00 |
| 28 | 2.1.2.4.3 Аж ахуй эрхлэгч иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлж, байнгын ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 500.0 | Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамруулсан хүний тоо | Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 49 иргэнийг хамруулж 470.7 сая төгрөгийг зарцуулсан. | Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 50 иргэнийг хамруулна. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөгдөх нөхцөлтэй "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа"-ны иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 47 иргэнд 450,000,000 төгрөгийг эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгоод байна. (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/30 дугаар "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны төсвийн хуваарийг батлах тухай" тушаалын дагуу хэрэгжүүлэн ажилласан) | | |
| 29 | 2.1.2.4.4 Аж ахуй эрхлэгч ахмад настанд санхүүгийн дэмжлэг үзүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 250.0 | Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамруулсан хүний тоо | Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 60 иргэнийг хамруулж 289.1 сая төгрөгийг зарцуулсан. | Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 50 ахмадыг хамруулна. | Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг үзүүлэх" арга хэмжээнд 47 ахмадын төслийг шалгаруулан 250,000,0 төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. /Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/30 дугаар "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваарийг батлах тухай" тушаалын дагуу хэрэгжүүлэн ажилласан./ | 100 | 100.00 |
| 30 | 2.1.2.4.5 Малгүй болон цөөн малтай өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгт хамруулж ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 480.0 | Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамруулсан хүний тоо | Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 165 өрхийг хамруулж 1.360.0 сая төгрөгийг зарцуулсан. | Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаанд 60 малчин өрхийг хамруулна. | Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгт 30 малчин өрхийг шалгаруулж, 240,000,000 төгрөгийг зарцуулсан. /Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/30 дугаар "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваарийг батлах тухай" тушаалын дагуу хэрэгжүүлэн ажилласан./ | 100 | 50.00 |
| 31 | 2.1.2.4.6 Залуучуудыг гарааны бизнесийг дэмжих санхүүгийн дэмжлэг үзүүлж ажлын байр бий болгоно | 10.0 | Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд | Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1 | Санхүүгийн дэмжлэгт 1 залуучуудын | Залуучуудын гарааны бизнесийг дэмжих Шилдэг старт- Апп 2 багийг шалгаруулж 50%-н эргэн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамруулсан хүний тоо | бүлэгт 10.0 сая төгрөгийг зарцуулсан. | бүлгийг хамруулна. | төлөлттэй 30,000,000 төгрөгийн санхүүжилт олгосон. | | |
| 32 | 2.1.2.4.7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 160.0 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулсан хүний тоо | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 18 иргэнийг хамруулж 137.6 сая төгрөгийг зарцуулсан. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 20 иргэнийг хамруулна. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэг"-т 41 иргэнд 200,000,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон. | 100 | 100.00 |
| 33 | 2.1.2.4.8 Түр ажлын байранд зорилтот бүлгийн иргэдийг зуучилж, орлогоор дэмжинэ. | 100.0 | Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо | Түр ажлын байранд 240 иргэнийг хамруулж 96.0сая төгрөгийг зарцуулсан | Түр ажлын байранд 400 иргэнийг хамруулна. | Мод арчлах,ургуулах арга хэмжээнд Хэрлэн, Батноров, Жаргалтхаан сум, Өлзийт тосгоны зорилтот бүлгийн 74 иргэнийг түр ажлын байранд зуучлан 35,472.000 төгрөгийг зарцуулсан. /Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/30 дугаар "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваарийг батлах тухай" тушаалын дагуу нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ хасагдаж ирсэн тул санхүүжилт болон хамруулах иргэдийн тоо буурсан. | 50 | 0.00 |
| 34 | 2.1.2.4.9 Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж | 59.4 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 2 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 70 ахмад мэргэжилтнийг түр ажлын байраар хангаж | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | | хамрагдсан хүний тоо | хүний хамруулж, 1.9 сая төгрөгийг зарцуулсан | 55 хүний хамруулж, 59.4 сая төгрөгийг зарцуулна. | 75.600.000 төгрөгийг зарцуулсан. | | . |
| **2.1.2.5 Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ** | | | | | | | | |
| 35 | 2.1.2.5.1 Байгууллагын удирдлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнуудад чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах | 5.0 | Сургалтад хамрагдсан хүний тоо /зохион байгуулсан сургалтын тоо/ | 209 ажилтан, ажил олгогч, иргэд сургалтад хамрагдсан. | 4 удаагийн сургалт зохион байгуулж 230 ажилтан, ажил олгогч, иргэдийг хамруулна. | Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилсан сэргийлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүднээс 33 удаагийн сургалт арга хэмжээг зохион байгуулж 247 аж ахуйн нэгж байгууллагын 2060 ажил олгогч, ажилтан инженер техникийн ажилтнуудыг хамруулсан. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийн 21 нарийн бичгийн даргыг Политехникийн коллежтой хамтран ХАБЭА-н мэргэшүүлэх 124 цагийн сургалтад хамруулсан. | 100 | 100.00 |
| 36 | 2.1.2.5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулах | 5.0 | Хяналт, шалгалтын тоо | 150 аж ахуйн нэгж, байгууллагад ажлын байрны үзлэг зохион байгуулсан | 4 удаагийн ажлын байрны хяналтын үзлэг зохион байгуулж 160 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулна | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг 4 удаа зохион байгуулж, 163 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан. | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэн, даатгуулагчийн амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ** | | | | | | | | |
| 37 | 2.1.3.1. Сайн дурын даатгалын болон сумдын байцаагч нар сумын багийн төвүүдээр малчид иргэд даатгуулагчдад сургалт сурталчилгаа хийх, шинээр сайн дурын даатгалд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэдийг хамруулах. | 9.4 | Сайн дурын даатгуулагчдын тоо | Сайн дурын даатгуулагчийн тоо 4850 | Сайн дурын даатгуулагчдын хамрагдалтыг нэмэгдүүлнэ. Даатгуулагчийн тоог 5335 хүргэнэ. | Нийгмийн даатгалын газрын байцаагч албан хаагчид 1-4 дүгээр улиралд сумдад сургалт зохион байгуулах, иргэд даатгуулагчид зөвлөгөө мэдээлэл өгөх, ажил олгогч даатгуулагчидтай уулзалт хийх ажлыг зохион байгуулан дараах хуваарийн дагуу ажилласан. Үүнд:1-р улиралд Дадал, Норовлин, Баян-Адарга, Биндэр 2-р улирал Баянхутаг, Баянмөнх, Дархан, Мөрөн 3-р улиралд Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр 4-р улиралд Батширээт, Батноров, Бэрх, Бор-Өндөр сумдад тус тус ажилласан. Сум, багийн иргэдийн нийтийн хурал, сум, багаас зохион байгуулсан малчид, хуваариа хөдөлмөр эрхлэгч, ногоочид, тариаланчдын зөвлөгөөнд холбогдох албан хаагчид мэдээлэл хүргэн ажилласан. Мөн сумдын байцаагч, ажилчдыг сумын багийн иргэдийн нийтийн хуралд жилд 2-с доошгүй удаа оролцох нөхцөл боломжоор хангаж шатахууны зардлыг хуваарилан сургалт | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурталчилгаа, үйл ажиллагаа зохион байгуулах нөхцөлийг сайжруулсан. 2025 онд сайн дурын даатгалын хамрагдалтын төлөвлөгөөгөөр шинээр 705 даатгуулагч хамруулан ажилласан. | | |
| **2.1.4.1 Иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг үзүүлж, тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ** | | | | | | | | |
| 38 | 2.1.4.1.1 Иргэдийг жилд нэг удаа бие бялдрын түвшин тогтоох сорилд хамруулах | | A,B,C үнэлгээний эзлэх хувь | 2024 онд сорилд хамрагдсан иргэдийн 50.9% нь A, B, C үнэлэгдсэн. | Сорилд хамрагдсан иргэдийн 52%-аас доошгүй нь A, B, C үнэлэгдэнэ | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлиг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Бие бялдрын түвшин тогтоох сорилын аяныг 2025 оны 04 дүгээр сарын 01-ээс 5 дугаар сарын 20-ний өдрийн хооронд аймгийн хэмжээнд зохион байгуулж сумд болон албан байгууллага, аж ахуй нэгж сургууль цэцэрлэгүүдэд сорилын баг гарган ажиллаж арга зүйн зөвлөгөө мэдээ мэдээлэл сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан ажиллаж 2025 онд аймгийн хэмжээнд 6500 иргэн сорилд хамрагдаж, 4517 иргэн буюу 69,5% нь A,B,C үнэлэгдсэн байна. | 100 | 100.00 |
| 39 | 2.1.4.1.2 Эрүүл амьдралын хэв маягийн мэдлэг олгох, | | Зохион байгуулсан | - | 5-аас доошгүй арга | Өглөөний дасгалыг өдөр бүр "Мөнхийн хайрын | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | | сургалт, нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан иргэдийн тоо | | хэмжээнд 500-аас багагүй иргэдийг хамруулсан байна. | урсгал ТББ Л. Арвинжаргалтай хамтран зохион байгуулж Өглөөний дасгал болон, Эрүүл амьдралын хэв маягийн мэдлэг олгох, төлөвшүүлэх, сургалтыг албан байгууллагуудаар зохион байгуулсан мөн Бие бялдрын түвшин тогтоох сорилын хүрээнд Сорилын баг гарган ажиллаж сургалтыг зохион байгуулж иргэд албан байгууллагаас сорилыг авч нийтдээ 25 байгууллага 250-н иргэнд сургалт мэдээллийн ажлыг хийж сумдын нийгмийн бодлого, биеийн тамирын арга зүйч, сорил хариуцсан ажилтан албан хаагчдад мэдлэг олгох зөвлөн туслах нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэсэн. | | |
| 40 | 2.1.4.1.3 Спортын холбоод, клуб, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжин иргэдийг биеийн тамир, спортын арга хэмжээнд хамруулах | | Биеийн тамирын арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | 2024 онд 37 спортын холбоо, клуб, ТББ-тай хамтран ажиллаж 16120 иргэн хамрагдсан | Биеийн тамирын арга хэмжээнд хамрагдагчдын тоо 300-аар нэмэгдсэн байна. | Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр "Мөнхийн хайрын урсгал ТББ, ЭМГ, БГ, НТСТөвтэй хамтран "Идэвхтэй хөдөлгөөн - Эрүүл Хэнтийчүүд" аяныг 2025 оны 10 дугаар сарын 08-аас 2025 оны 12 дугаар сарын 08-ны хооронд 2 сарын хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулж аяны хүрээнд дасгал хөдөлгөөний ач тус, зөв хооллолт, эрүүл амьдралын идэвхтэй хэв маягийн мэдлэг олгох, төлөвшүүлэх | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж дасгал хөдөлгөөнд 21580 иргэн, 22 удаагийн сургалт нөлөөллийн арга хэмжээнд 1594 иргэн нийт 23144 иргэн амжилттай хамрагдсан байна. Аяны арга хэмжээнд аймгийн Засаг даргын зүгээс 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | | |
| **2.1.4.2 Өсвөрийн шигшээ багийг дэмжин ажиллана** | | | | | | | | |
| 41 | 2.1.4.2.1 Өсвөр үеийн шигшээ багийн сургалт-дасгалжуулалтыг тогтмол хичээллүүлж, улс, бүс, олон улсын тэмцээнд амжилт үзүүлэх | 150.0 | Батлагдсан спортын нэр төрлөөр хичээллэж, улс, бүс, олон улсын тэмцээнд үзүүлсэн амжилтаар | 2024 онд спортын 15 төрлөөр хичээллэж, УАШТ-ээс 34 алт, 34 мөнгө, 27 хүрэл, Ази Тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 1 мөнгөн, 1 хүрэл медаль тус тус хүртсэн. | Тэмцээн уралдаанд амжилттай оролцсон байна. | Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн үеийн шигшээ багт 2025 онд 150 сая төгрөгийн санхүүжилттэй 14 спортын төрөлд 358 тамирчид сургалт-дасгалжуулалтад хамрагдан үйл ажиллагаа явуулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 25 удаагийн тив, олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд давхардсан тоогоор 423 тамирчин оролцож улсын аварга шалгаруулах тэмцээнээс 127, олон улсын тэмцээнээс 2 багц медаль тус тус хүртсэн амжилт үзүүлж, 3 тамирчин спортын мастер, 8 тамирчин спортын дэд мастерын болзол хангасан. Өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагч багш нартай аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч нар 2 удаа уулзаж тайлан мэдээлэл сонсож цаашид хамтран | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллах талаар санал солилцож үүрэг чиглэл өгч ажилласан. | | |
| **2.1.4.3 Үндэсний спорт болон спортын наадам, тэмцээн уралдаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ** | | | | | | | | |
| 42 | 2.1.4.3.1 Спортын наадам, тэмцээн уралдаанд оролцогчдод дэмжлэг үзүүлэх | 50 | дэмжлэг үзүүлсэн тоо | Үндэсний спортын наадам, Монголын бүх ард түмний спортын наадам, Хүүхдийн спортын наадамд нийт 111 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 2 удаа /Монголын Хүүхдийн спортын ҮIII наадам, Монголын бүх ард түмний спортын XVI наадам/ | Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 2 жил тутамд зохион байгуулагддаг Монголын Хүүхдийн спортын зуны VIII наадмын шигшээ тэмцээнд Хэнтий аймгийн 209 өсвөрийн тамирчин спортын 20 төрөлд оролцож 3 алт, 6 мөнгө, 8 хүрэл медаль хүртэж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 50,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Монголын Хүүхдийн спортын өвлийн VIII наадмын шигшээ тэмцээнд Хэнтий аймгийн 14 өсвөрийн тамирчин спортын 3 төрөлд оролцож 1 алт, 1 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн ба наадамд оролцогчдод аймаг орон нутгаас 7,624,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Монголын Бүх Ард түмний спортын XVI наадамд үндсэн 16 төрөлд 111 тамирчин оролцож 7 алт, 6 мөнгө, 5 хүрэл нийт 18 багц медаль хүртэж Хэнтий аймаг шагналт 5-р байрт, ХБИ-ийн спортын 5 | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрөлд оролцон 6 алт, 3 хүрэл медаль нийт 8 багц медаль хүртэж шагналт 3-р байрт тус тус шалгарсан. Тус наадамд оролцоход аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас 5.2 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлж хамтран ажилласан. | | |
| 43 | 2.1.4.3.2 Тамирчдад Тив, Дэлхий, Олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх | 20.0 | Дэмжлэг үзүүлсэн тэмцээн уралдааны тоо | 2024 онд 11 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | Дэмжлэг үзүүлсэн байна. | 2025 оны хагас жилээр аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн Тамирчдад Тив, Дэлхий, Олон улсын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх зардлаас:<br>1. Вьетнам улсын Вунг Тау хотноо зохион байгуулагдсан U17 насны Ази тивийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнд өсвөр үеийн шигшээ багийн тамирчин чөлөөт бөхийн спортын дэд мастер А.Тайванбатад 2.0 сая төгрөг,<br>2. А.Дөлгөөн багштай Доминго" бүжгийн хамтлаг Филиппин улсын Манила хотод зохион байгуулагдах Ази тивийн аварга шалгаруулах бүжгийн спортын нээлттэй тэмцээнд оролцох 1.0 сая төгрөг,<br>3. БНХАУ-ын Ханжоу хотод 2025 оны 06 дугаар сарын 06-14-ний өдрүүдэд зохион байгуулагдах Параволейболын Ази | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тивийн аварга шалгаруулах тэмцээнд монгол улсаа төлөөлөн оролцох Б.Доржид 1.0 сая төгрөг,<br>4. Хэнтий аймгийн Биндэр сумын харьяат спортын дэд мастер Х.Эрдэнэтунгалагт Хятад улсын Харбин хотод зохион байгуулагдах цаны Азийн их наадамд оролцоход 500 мянган төгрөг,<br>5. Хэрлэн нэгдүгээр сургуулийн сурагч Б.Далайцэрэн нь Турк улсын Анталиа хотод зохион байгуулагдах тэмцээнд оролцоход 1.0 сая төгрөг,<br>Батноров сумын харьяат Ц.Өнөрбатад дэлхийн аварга шалгаруулах модон барилдааны тэмцээнд Оросын холбооны улсын Саха - Якут хотноо олон улсын хамтарсан бэлтгэлд оролцоход 1.0 сая төгрөг нийт 6,5 сая төгрөгийг зарцуулсан байна. | | |
| 44 | 2.1.4.3.3 Орон нутагт УАШТ зохион байгуулах | 10.0 | Дэмжлэг үзүүлсэн тэмцээн уралдааны тоо | 2024 онд 8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | Дэмжлэг үзүүлсэн байна. | Жилийн эцсийн байдлаар:<br>1. Өсвөрийн Улсын аварга шалгаруулах Волейболын тэмцээнд оролцсон өсвөрийн баг тамирчдад 1.0 сая төгрөг<br>2. Хүндийн өргөлтийн өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд 1.0 сая төгрөг | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Улаанбаатар хотод зохион байгуулагдах өсвөрийн шатарчдын Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдад 500 мянган төгрөг<br>4. Эрдэнэт хотын "Сархиа" цанын баазад зохион байгуулагдах "Хүүхдийн спортын их наадамд" гүйлтийн цанын төрөлд оролцох тамирчдад 1.0 сая төгрөг<br>5. Хүндийн өргөлтийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээний зардалд 2,5 сая төгрөг<br>6. Спортын мастер Г.Эрдэнэбилэгийн нэрэмжит Зүүн бүсийн аварга шалгаруулах Жүдо бөхийн тэмцээн 2.5 сая төгрөг<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй Улсын аварга шалгаруулах Тийболлын тэмцээнд хэнтий аймгаа төлөөлөн Бор-Өндөр сумын баг тамирчид оролцоход 1.5 сая төгрөг нийт 10 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн байна. | | |
| 45 | 2.1.4.3.4 Монголын үндэсний уламжлалт спорт морь, бөх, сур, шагайн төрлүүдээр орон нутагт зохион байгуулах | 20.0 | Дэмжлэг үзүүлсэн үндэсний спортын | Үндэсний спортын төрөлд 2024 онд 20 сая төгрөгийн | Монголын Үндэсний спортын уламжлалт соёлыг түгээн | 2025оны 2 дугаар сард зохион байгуулсан XVII жарны хөхөгчин могой жилийн сар шинийн баярт зориулсан "Өндөрхааны | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тэмцээн уралдааны тоо | дэмжлэг үзүүлсэн | дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | цом" үндэсний бөхийн барилдааны зардалд 10.0 сая төгрөг,<br>2025 оны 6 дугаар сард зохион байгуулсан Сэцэн Ханы Мэргэд харваачдын нэгдсэн холбооноос Үндэсний их сурын нээлтийн харвуул тэмцээн зохион байгуулах зардалд 5,0 сая төгрөг, Аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулагдсан "Хэрлэнгийн тойром-2025" үндэсний шагайн харвааны тэмцээнд 5 сая төгрөг зэрэг Монголын үндэсний спортын уламжлалт соёлыг дэлгэрүүлэхэд нийт 20 төгрөгийн дэмжлэг үзүүлж тус арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулсан. | | |
| **2.2 БОЛОВСРОЛ** | | | | | | | | |
| **2.2.1.1. Бүх шатны боловсролын байгууллагын чанар хүртээмжийг сайжруулна** | | | | | | | | |
| 46 | 2.2.1.1.1 Бүх шатны сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний бичгийн шалгалтын хувийг ахиулах | 25.0 | бичгийн шалгалтын гүйцэтгэлийн хувь | СӨБ 89.3 % ЕБС 48.6 % | 1% ахиулна | 2025 оны сургалтын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 33 цэцэрлэгийн 195 багш, 2887 хүүхэд; ерөнхий боловсролын сургуулийн 28 сургуулийн 749 багш, 17393 суралцагч хамрууллаа.<br>Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний бичгийн шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сургалт нөлөөллийн ажлыг хийхээс гадна байгууллагын | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | менежментийн зураглалд сургалтын чанарыг сайжруулахаар 2 удаагийн хэлэлцүүлэг өрнүүлж ажлын төлөвлөгөөг тулгамдсан агуулга, сэдэв, танин мэдэхүйн түвшинтэй уялдуулан ажиллалаа. СӨБ-ын үнэлгээг чадамж болон ажиглалт, асуулгаар ЕБС-ийн үнэлгээг 1-5 дугаар ангийн үнэлгээг цаасан суурьтай, 6-12 дугаар ангийн үнэлгээг цахим суурьтай зохион байгуулсан бөгөөд 2025 онд СӨБ-ын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ 86.3% үнэлэгдэж өмнөх оноос 3%-аар буурсан үзүүлэлтэй байгаа бол ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт 62.2% болж өмнөх оноос 13.51%-аар өссөн үзүүлэлттэй байна. | | |
| 47 | 2.2.1.1.2 Ментор багшийг ажиллуулж, математик, байгалийн ухааны багш, сонгосон сурагчдыг чадавхжуулах | 30.0 | Хамрагдсан багш, сурагчдын тоо, | 0 | Багш 90 Суралцагч 400 | Хэнтий аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр Нийгмийн бодлогын хэлтэс, Хүртээмжтэй боловсрол багш нарын нэгдэл ТББ, Шинэ зууны боловсролын түлхүүр ТББ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд 2025 оны 03 сарын 15, 16 -ны өдрүүдэд Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль дээр нийгмийн ухааны 42, | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | химийн 20, физикийн 22, англи хэлний 50, математикийн 52 нийт 186 багшийн танхимын сургалтыг зохион байгууллаа. Боловсролын газрын судлагдахуун хариуцсан ахлах арга зүйчид сонгогдсон судлагдахуунаар фэйсбүүк групп нээн ажиллуулж Математик 971, англи хэл 719, хими 221, нийгэм 523, физик 211 нийт давхардсан тоогоор 2345 суралцагчийг хамруулан Хүртээмжтэй боловсрол төвийн хичээлүүдийг байршуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд 1 удаа сорилго шалгалт авч үзвэл Аймгийн хэмжээнд 12 дугаар ангийн давхардсан тоогоор 1664 шалгуулагч шалгуулахаас 1585 шалгуулагч шалгуулж шалгалтын дундаж гүйцэтгэл 33,9% -тай байсан бол 2025 оны элсэлтийн шалгалтын дүн оноог авч үзвэл 13 сургуулийн 791 суралцагч 2441 шалгалтыг өгч хэмжээст онооны дундаж 507,6 болж өсөөд байна. 2024 оны элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж 506,6 байсан бөгөөд 2025 онд ХОД нь 1 оноогоор буюу 1,9 хувиар өссөн байна. Судлагдахууны хувьд орос | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэл, англи хэлний судлагдахуунаас бусад судлагдахуун улсын дунджаас дээгүүр үнэлгдэж 400 дээш оноо авсан шалгуулагчийн хувь 86,5 хувийг эзэлж байна. | | |
| 48 | 2.2.1.1.3 СӨБ-д хамрагдах хүүхдийн хувийг нэмэгдүүлж, СББҮнэлгээг 5% нэмэгдүүлэх | | 2-4 настны хамрах хувь, 5 настны хамрах хувь, СББҮ ахисан хувь байна. | 2-4 настны хувь-89.1 5 настны хувь-95.9% СББҮ-72.9% | 90% 100% 74% | 2025-2026 оны хичээлийн жилд 2-5 хүртэлх настай хүүхэд бүрийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах талаар БГ, цэцэрлэгүүдээс мөшгих судалгаа хийж, 6353 хүүхдээс 5906 хүүхэд /93%/-ийг 35 цэцэрлэгийн үндсэн болон хувилбарт сургалтад хамруулсан бол 5 настай хүүхдийн 99.5%-ийг үндсэн болон хувилбарт сургалтад хамруулж байна. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 79.4 болж хүрэх түвшингээс 6.5%-аар ахисан. | 100 | 100.00 |
| | | | | | | хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах эргэн төлүүлэх, хяналт тавих журам" -ын хэрэгжилтийг ханган ажиллах, зээлдэгчдэд сургалт зохион байгуулж, мэдээллээр хангах, ХХСангийн Хороо, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг жигдрүүлж, сайжруулан ажиллах талаар зөвлөмж, зөвлөгөөг газар дээр нь өгч ажилласан. | | |
| 97 | 3.1.6.2 Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 50 хувиар нэмэгдүүлэх | 20.2 | Зээлийн эргэн төлөлтийн хувь | Хоршоо хөгжүүлэх сангийн нийт 5.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна | 30% | Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор бүх сум, тосгонд ажиллаж зээлийн эргэн төлөлтөд хяналт хийж ажиллав. Зээлийн эргэн төлөлтөөр 2025 оны жилд 1132,8 сая төгрөгийн зээлийг барагдуулахаар төлөвлөснөөс 1047,5 сая төгрөгийн зээлийг төлүүлээд байна. | 90 | 100.00 |
| **3.1.7 Орон нутгийн өмчийн ашиглалт үр өгөөжийг нэмэгдүүлэх** | | | | | | | | |
| 98 | 3.1.7.1 Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын гэрээг жил бүр бүрэн дүгнэж, гэрээ байгуулж, эд хөрөнгийн ашиглалт хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах | 12,0 | 187 байгууллагын гэрээг дүгнэсэн хувиар | 187 байгууллагын гэрээ дүгнэж баталгаажуулсан. | 100 | 187 байгууллагын өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэсэн. Үүнээс 89 байгууллага буюу 55 хувь нь хангалтгүй үнэлгээ авч үлдсэн 45 хувь нь дунд, сайн үнэлгэдсэн байна. | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1.8 Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны тоог нэмэгдүүлж, худалдан авах ажиллагааг ил тод байлгана.** | | | | | | | | |
| 99 | 3.1.8.1 Дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой бараа, бүтээгдэхүүнийг хэрхэн тендерийн баримт бичигт оруулах талаар төсвийн байгууллагуудад сургалт зохион байгуулах | - | Сургалтад хамрагдсан байгууллага, албан хаагчдын тоо | - | 150 | МУ-ын Засгийн газрын 2019.02.27-ны өдрийн 90 тогтоолын дагуу 18 сум 4 тосгоны худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, үнэлгээний хорооны гишүүдэд дотоодод үйлдвэрлэсэн барааг худалдан авахдаа тендерийн баримт бичигт зайлшгүй тусгах багц болгон зохион байгуулах талаарх зөвлөмж мэдээлэл, сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 12, 13-нд Хан-Хэнтий чуулгад хийсэн. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 22, 26-нд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран Биндэр, Баян-Адарга, Батширээт, Норовлин, Дадал сумдад очиж сургалт хийсэн. Нийт сургалтад 210 хүн хамрагдсан. | 100 | 100.00 |
| 100 | 3.1.8.2 Аймгийн хэмжээнд зарлагдсан төсөл арга хэмжээнд дотоодод үйлдвэрлэсэн барааны нэр төрөл, үнийн дүнг тусгах | - | Тусгагдсан үнийн дүн | 484,0 | 600,0 | Худалдан авах ажиллагааны газраас зарласан 48 төсөл арга хэмжээнд хуулийн 8 дугаар зүйл дотоодын үйлдвэрлэлийг дэмжих давуу эрх тооцох талаар тендерийн баримт бичигт тусгаж оруулсан. Үүний дагуу "Нэгдсэн эмнэлгийн гадна фасадны засвар"-ын ажлын тендер шалгаруулалтад шаардлагыг хангасан нэг | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцогчид давуу эрх тооцож олгосон ба тендерт шалгаруулалтын төсөвт өртөг 829,0 сая төгрөг. | | |
| 101 | 3.1.8.3 Худалдан авах ажиллагааны шалгалтыг зохион байгуулж анхан шатны мэргэшсэн гэрчилгээ /А-3/ бүхий төрийн албан хаагч, иргэд олон нийтийн тоог нэмэгдүүлэх | - | Мэргэшүүлэх шалгалтад тэнцсэн хүний тоогоор | 216,0 | 35-аас дээш | 2025 онд А3 сертификат олгох шалгалтыг 5 удаа зохион байгуулж, шинээр 138 хүн тэнцсэн. Хэнтий аймагт А3 гэрчилгээтэй 339 төрийн албан хаагч, төрийн бус байгууллага, иргэний төлөөлөл байна. | 100 | 100.00 |
| 3.2. ТӨРӨЛЖСӨН ЭДИЙН ЗАСАГ | | | | | | | | |
| 3.2.1. Уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах хүнд үйлдвэрийн төслүүдийг дэмжиж ажиллана. | | | | | | | | |
| 3.2.1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Бор-Өндөр суманд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ. | | | | | | | | |
| 102 | 3.2.1.1.1 Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, уул уурхайн түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах төслийг дэмжиж, хамтран ажиллах | - | Дэмжиж, хамтран ажилласан эсэх | - | + | Үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар Бор-Өндөр суманд 787 га газрыг сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж батлуулан, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжуудад нийцүүлэн газрыг улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, дэмжсэн санал бүхий тогтоолыг ЗГХЭГ болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлсэн. Төслийн хэрэгжүүлэгч "Эрдэнэс | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол ҮТП" ХХК-д Үйлдвэрлэл, технологийн паркийн тусгай зөвшөөрөл авах саналыг мөн дэмжиж АҮЭБЯаманд уламжилсан. Дээрх асуудлууд шийдэгдсэнээр төслийн дэд бүтэц, барилга байгууламжийг барих ажлын болон үндсэн үйлдвэрүүдийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж, хөрөнгө оруулалтын загвар тодорхойлогдоод байгаа бөгөөд төслийн хамгийн гол бичиг баримт болох 2035 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл бэлэн болсон байна. | | |
| 103 | 3.2.1.1.2 Түгээмэл тархацтай ашигт малтмалын эрдэс түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих | | Дэмжиж, хамтран ажилласан эсэх | - | + | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2 ААН ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулах ТЭЗҮ болон БОНМТ, уулын ажлын төлөвлөгөөг батлуулж үйл ажиллагаагаа эхлүүлснээр аймаг орон нутгийн бүтээн байгуулалт, дэд бүтцийн ажил, иргэдийн ахуйн хэрэгцээнд болон зуурмагийн үйлдвэрүүдэд нэн шаардлагатай байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалын эрдэс түүхий эдийн нийлүүлэлтийг хийж, дотоодын үйлдвэрлэл, эдийн засгийн эргэлтийг бий болгоод байна. 2025 онд 1 | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аж ахуйн нэгжийн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2 аж ахуйн нэгжийн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон дэмжиж цаашид үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлээд байна. | | |
| 3.2.2. Зорчигч иргэдийг тав тухтай, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | |
| 3.2.2.1. Хот хооронд болон хот доторх зорчигч тээврийн болон авто үйлчилгээ эрхлэгчдийг стандартын шаардлага хангуулна. | | | | | | | | |
| 104 | 3.2.2.1.1 Зүүн бүсийн шуудан логистикийн төв байгуулах | Батлагдсан төсвийн хүрээнд | Гүйцэтгэлийн хувиар | - | 25 | "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн зүүн бүсийн чуулган 2025" зохион байгуулагдах үеэр аймгийн Засаг дарга Монгол шуудан ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд орон нутагт шуудангийн илгээмжийн "Зүүн бүсийн шуудан логистикийн төв" байгуулах ажлын хүрээнд тус төвийг байгуулахад шаардлагатай 5 га газрыг Зүүн бүсийн шуудан логистикийн төв байгуулах 5га газрын асуудлыг Мөрөн сумын нутагт шинээр баригдаж байгаа Хэрлэн голын төмөрбетон гүүр, 14км хатуу хучилттай автозам дагуу байршилд төлөвлөж Мөрөн сумын | 40 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлж сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулан шийдвэрлүүлсэн. | | |
| 105 | 3.2.2.1.2 Хот доторхи такси үйлчилгээ эрхлэгч нарыг бүртгэлжүүлэх | - | Бүртгэлжүүлэх ажлын хэрэгжилтийн хувиар | - | 30 | Чингис хотын доторх такси үйлчилгээ эрхлэгчдийг бүртгэлжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталж, хэрэгжилтийг зохион байгууллаа. Уг ажлын хүрээнд “UB CAB” аппликейшнтэй хамтран ажиллаж эхний шатанд 25 жолоочийг бүртгэлжүүлсэн бөгөөд бүртгэл нэмэгдсээр аймгийн хэмжээнд нийт 700 гаруй жолооч буюу хот доторх такси үйлчилгээ эрхлэгчид 100 хувь бүртгэгдээд байна. Үүнээс 50–100 жолооч тогтмол, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. | 100 | 100.00 |
| 3.2.2.2. Улсын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангана | | | | | | | | |
| 106 | 3.2.2.2.1 Улсын чанартай авто замын засвар арчлалтын ажлын батлагдсан норм дүрмийг мөрдлөг болгож гүйцэтгэх | - | Гүйцэтгэлийн хувиар | - | 100 | Аймгийн нутаг дэвсгэрт байрлах олон улс, улсын чанартай авто замын бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалах ажлыг АЗЗАН ТӨХК Хэнтий салбарт үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг тухай бүр хангуулсан. Мөн аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар албан даалгаврын дагуу өвөлжилтийн бэлтгэл | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын төлөвлөгөө гаргуулан А0501 Улаанбаатар-Өндөрхаан, А0502 Өндөрхаан-Чойбалсан, А19 Өндөрхаан-Баян-Уул чиглэлүүдэд Шуурхай ажлын хэсэг гаргаж, хүн хүч, тоног төхөөрөмжийн бэлэн байдалд бэлтгэн биелэлтийг 100% хангасан. 2025 онд А0501 Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн 176км-333км хүртэл, А0502 Өндөрхаан-Чойбалсан 1км-178км хатуу хучилттай авто замын засвар арчлалтын ажлыг 100% хийж дуусгасан. | | |
| 107 | 3.2.2.2.2 Орон нутгийн чанартай авто замын засвар арчлалтын ажлын батлагдсан норм дүрмийг мөрдлөг болгож гүйцэтгэх | Батлагдсан төсвийн хүрээнд | Гүйцэтгэлийн хувиар | - | 100 | 2025 онд Орон нутгийн чанартай авто замын засвар арчлалтыг хангах зорилгоор Орон нутгийн замын сангийн 1390.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөгдсөн бөгөөд үүнээс он дамжсан 5 төсөл арга хэмжээг ашиглалтад оруулж гүйцэтгэлийн зургийг urban.gov.mn сайтад тухай бүр оруулан мэдээллийн санг үүсгэж ажилласан. ОНТ-ийн 895.5 сая төгрөгийн хөрөнгөөр Чингис хот доторх авто замыг засварлах, арчлах ажлыг 100% хийж гүйцэтгэсэн. | 100 | 100.00 |
| **3.2.3. Хэрэглэгчдийг чанартай, найдвартай дулаан хангамж, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангаж, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.3.1. Дулааны станцын дулаан дамжуулах төвүүдийн инженерийн шугам сүлжээний ажлын өргөтгөлийг гүйцэтгүүлж, дулааны станцын 17ш ДДТ-ийн ИШС-ний засвар, шинэчлэлийн ажлыг үе шаттайгаар ашиглалтад оруулна. | | | | | | | | |
| 108 | 3.2.3.1.1 Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл - 4 дүгээр ээлж /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах | 16296.14 | Гүйцэтгэлийн хувиар | - | 30 | 2025 оны аймгийн ОНХСангийн 150сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл - 4 дүгээр ээлжийн ажлын зураг, төслийн гүйцэтгэгчээр "Анга трасс" ХХК шалгаран 2-р улиралд зураг төслийг 100% дуусгаж хүлээлгэн өгсөн. Тус Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам засвар, шинэчлэл - 4 дүгээр ээлж ажил нь Эрчим хүчний сайдын багцад 15.4 тэрбум төгрөгийн төсөвтэй батлагдаж тендер 3 удаа зарлагдаж, гүйцэтгэгчээр "Баткомплект" ХХК шалгарч 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдөр гэрээ байгуулсан. | 100 | 100.00 |
| 109 | 3.2.3.1.2 Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах | 8143.8 | Гүйцэтгэлийн хувиар | 30 | 70 | Дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл арга хэмжээ нь 3 багцад задарч тендер зарлагдсан. Багц-2 Дэд бүтэц /Усан хангамж, ариутгах татуурга/ төсөл арга хэмжээний хүрээнд 600м бохир, 700м цэвэр усны шугамын ажил хийгдэж тус оны санхүүжилтэд тусгагдсан | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлаа 100% хийж гүйцэтгэсэн. Багц-1 Цахилгаан хангамж /Дулааны станц, дулаан дамжуулах төв/ болон Багц-3 Холбоо мэдээлэл /Дулааны станц, дулаан дамжуулах төв/ төсөл, арга хэмжээнүүд 100% хэрэгжиж дууссан. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллахад бэлэн болоод байна. | | |
| | 3.2.3.2. Багануур-Чингис-Чойбалсан чиглэлийн 220кВ-ын 518 км цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажлыг эхлүүлнэ | | | | | | | |
| 110 | 3.2.3.2.1 Холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | - | Дэмжлэг үзүүлсэн эсэх | Суурь судалгаа хийгдэж, ТЭЗҮ боловсруулагдсан. | хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхэд орон нутгаас шаардлагатай дэмжлэг үзүүлэх | "Багануур-Чингис-Чойбалсан чиглэлийн 220кВ-ын 518 км цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралт" төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх саналыг Эрчим хүний яамнаас Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй. Тус төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа талаар аймаг орон нутгаас ойрын хугацаанд хэрэгжүүлэх "Ач холбогдол бүхий төсөл арга хэмжээ"-ний жагсаалтад тусгаж, Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн болон Зүүн бүсийн зөвлөлд удаа дараа хүргүүлж ажилласан. | 100 | 0.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.3.3. Нар, салхины сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг төр, хувийн хэвшил, оролцоотойгоор хэрэгжүүлж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 111 | 3.2.3.3.1 Хэрлэн суманд 30 мВА чадалтай батерей хуримтлуууртай нарны сэргээгдэх эрчим хүчний зураг төслийг боловсруулах. | 200.0 | Гүйцэтгэлийн хувиар | Холбогдох суурь судалгаа хийсэн. | 30% | Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ-ыг ЦЭХ-ээр хангах 60квт-ын нарны эх үүсгүүр суурилуулан ашиглалтад оруулсан. Мөн Цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга бага чадлын 2 кВт хүчин чадалтай нарны эх үүсгүүр суурилуулж аваарын үед ашиглаж байна. "Хэрлэн суманд 30 мВА чадалтай батерей хуримтлуууртай нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр" төсөл арга хэмжээний суурь судалгаа хийгдсэн, ажлын даалгавар боловсруулагдсан. ТЭЗҮ хийгдэх, хэрэгжүүлэх төсөв батлагдаагүй.<br>Цэнхэрмандал сумын Бүрэн уулын орчим Хэрлэн голд Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100МВт хүртэл хүчин чадалтай усан цэнэгт цахилгаан станцын ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нээлттэй зарлаад байна. | 100 | 100.00 |
| 112 | 3.2.3.3.2 Шинээр баригдах барилга байгууламжид ЦЭХ-ний техникийн нөхцөл олгохдоо нөөц үүсгүүрийг | | Барилгын тоо | - | 2 | Иргэд, ААН, байгууллагаас ирүүлсэн 248 техникийн нөхцөл авах хүсэлтийг 100% шийдвэрлэсэн. Үүнээс сэргээгдэх эрчим | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргээгдэх эрчим хүчээр шийдэх талаар тусгах. | | | | | хүчээр эх үүсгүүрийг шийдэх талаар тусгагдсан 3 техникийн нөхцөлийг олгосон. | | |
| **3.2.4. "Шинэ хоршоо", "Цагаан алт" хөдөлгөөнийг хэрэгжүүлж, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| **3.2.4.1. Малын гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх хоршоодыг нэмэгдүүлэн, дундын хоршоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.** | | | | | | | | |
| 113 | 3.2.4.1.1. Хоршоодыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах, сайн туршлагыг сурталчлах | 5.0 | Зохион байгуулсан сургалт, оролцогчдын тоогоор | 2024 онд Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 468 хоршоо шинээр байгуулагдаж Засгийн газар, Хөгжлийн шийдэл ТББ, ХААХХолбоотой хамтран 8 сургалт зөвлөгөөн зохион байгуулан давхардсан тоогоор 120 хоршооны 380 гаруй хоршоологчид хамрагдсан | 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулж 100-аас доошгүй хоршооны гишүүдийг хамруулна. | Монгол улсын Шадар сайд, "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны дарга С.Амарсайханы 2025 оны 32 дугаар тушаалын хүрээнд Чингис хотод 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр "Аймгийн хоршоологчдын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, 18 сумын 360 гаруй малчин, хоршоологч, хоршоо хариуцсан мэргэжилтнүүд оролцсон. Мөн 5 суманд "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хэрэгжилтийг сурталчлан таниулах малчид, хоршоологчдын зөвлөгөөн зохион байгуулж, 900 гаруй иргэд, малчид хамрагдсан. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий мэдээллийг түгээх, хоршоодын сайн туршлагыг олон нийтэд сурталчлах ажлыг "Шинэ хоршоо хөдөлгөөн" пейж хуудас, Хэнтий мэдээ сонин, Хэнтий Жи тайм, 24 цаг, Aruukhan.mn сайтуудаар дамжуулж олон нийтэд | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түгээж ажиллалаа. 2025 онд 97 хоршооны 132 малчин 5.1 тэрбум төгрөгийн хоршооны зээлд хамрагдаж санхүүгийн дэмжлэг аваад байна. | | |
| 114 | 3.2.4.1.2. Хоршоодыг хөнгөлөлттэй зээлд хамруулах. | - | Зээл авсан хоршоодын тоогоор | 2024 онд ХХС-аас 14 хоршоонд 604.7 сая төгрөгийн зээл олгосон. | 10-с доошгүй хоршоонд зээлийн дэмжлэг үзүүлнэ | Хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “Хоршоо хөгжүүлэх сан”-аас 9 сумын 24 хоршоонд 1333.5 сая төгрөгийн зээлийг олгосноор 24 ажлын байр хадгалагдаж, шинээр 30 ажлын байр бий болгоод байна. | 100 | 100.00 |
| 115 | 3.2.4.1.3. Хоршоо, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв байгуулж, үйл ажиллагаа эрхлэгчдэд сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх. | 32.5 | гүйцэтгэлийн хувиар, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тоогоор | - | Ашиглалтад орсон байна. | Хүнс, хөдөө аж ахуйн газрын хуучин барилгыг дахин ашиглалтад оруулж, "Хоршоо, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв" болгон аймгийн Хоршоологчдын холбоотой гэрээ байгуулж үйл ажиллагааг хариуцуулсан ба одоогоор 6 жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжиж түрээсгүй ажлын байраар ханган ажиллаж байна. Тус төвийн бойжигчдоос "Ур Өрнөх Анухай" ХХК нь "Амар байна уу" үзэсгэлэн худалдаанд оролцож 1.2 сая төгрөгийн борлуулалт, бусад 5 үйлдвэрлэгчид Зүүн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бусийн ахуйн үйлчилгээний зөвлөгөөн, "Ахуйн үйлчилгээ-2025" нэгдсэн арга хэмжээнд тус тус оролцож үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна. | | |
| **3.2.4.2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 116 | 3.2.4.2.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр анхан шатны боловсруулах үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ. | - | Хөнгөлөлттэй зээл олгосон тоогоор | Анхан шатны 5 үйлдвэр байгуулахад ХХС-аас 338.7 сая төгрөгийн зээл олгосон. | 1-с доошгүй анхан шатны үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгоно. | Малын гаралтай түүхий эд боловсруулах анхан шатны үйлдвэр байгуулах чиглэлээр Батноров сумын "Хүрдэтийн гурван бүрд" хоршоо 80,0 сая, Бор-Өндөр сумын "Сод төгс жаргал урлан" хоршоонд арьс ширэн эдлэл хийх ажлын байр барихад 70.0 сая, мах боловсруулах чиглэлээр Норовлин сумын "Цохонд" хоршоонд 30,0 сая төгрөг, нийт 180,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг "Хоршоо хөгжүүлэх сан"-гаас, Өмнөдэлгэр сумын "Гоё алтай" ХХК мах боловсруулах үйлдвэрт 130.0 сая төгрөгийн зээлийг Бизнес эмэгтэйчүүдийг дэмжих төслөөс тус тус олгож дэмжлэг үзүүлснээр малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн тоо өнгөрсөн оноос 2.5 хувь, ажлын байр 8-аар нэмэгдээд байна. | 100 | 100.00 |
| 117 | 3.2.4.2.2. Гарааны бизнес эрхлэгчдийг жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, | - | Бойжсон болон дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн | 11 гарааны бизнес эрхлэгчдэд 99.5 сая | 5 доошгүй иргэд, аж ахуйн нэгжийг | Жендэрийн үндэсний хороо, Азийн хөгжлийн банк хамтарсан "Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бизнес инкубатор төвүүдээр бойжуулж, дэмжлэг үзүүлнэ. | | нэгжийн тоогоор | төгрөгийн зээл олгосон. Хөдөө аж ахуйн дэмжих төвөөр 12 иргэн аж ахуйн нэгж бойжиж байна. | бойжуулсан байна | болон жендэрийн мэдрэмжтэй бодлогоор дамжуулан хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлыг сайжруулах нь төсөл"-д 2 сумын 1 аж ахуйн нэгж, 3 иргэн хамрагдаж, 20.0 мянган долларын буюу 68.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэгт хамрагдсан. Мөн Хөдөө аж ахуйг дэмжих төвийг Хэрлэн сумын ЗДТГ-т шилжүүлэн шинээр 10 иргэнийг ажлын байраар хангаан худалдаа үйлчилгээ эрхлэх гараашны бизнесийг дэмжсэн. | | |
| 118 | 3.2.4.2.3. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг гадаад дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцож, туршлага судлуулахад дэмжлэг үзүүлэх | 2.5 | Туршлага судалж оролцсон арга хэмжээний тоогоор | 6 арга хэмжээнд 105 жижиг дунд үйлдвэрлэгчид оролцсон. | Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг 2-с доошгүй арга хэмжээнд оролцуулж, туршлага судлуулна. | Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих, худалдаа, борлуулалтыг нэмэгдүүлэх, нутгийн брэнд бүтээгдэхүүний нэр төрөл, сав баглаа, боодол, чанар хүртээмжийг сайжруулах, хэрэглэгчдэд сурталчлах, түгээх зорилготой гадаад, дотоодын 10 удаагийн үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 417 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулж, 403.0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. 2025 оны 12-р сарын 18, 27-ны өдрүүдэд ӨМӨЗО-ны Манжуур хотод болох үзэсгэлэн худалдаанд 4 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийг оролцуулж, | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | туршлага судлуулахаар бэлтгээд байна. | | |
| **3.2.4.3. Ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулж, үйлчилгээний салбарт ажиллагсдыг чадавхжуулна.** | | | | | | | | |
| 119 | 3.2.4.3.1. Төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ахуйн үйлчилгээний нэгдсэн төв байгуулахад дэмжлэг үзүүлэх. | - | Гүйцэтгэлийн хувиар | - | 10 | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр Жаргалтхаан, Хэрлэн, Мөрөн сумдад ахуйн үйлчилгээ бүхий 10 барилга байгууламж, төвүүд ашиглалтад орж 27 ажлын байр нэмэгдүүлсэн. Мөн "Ханбогд кашмер" ХХК нь тус аймагт ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр, ахуй үйчилгээний төв байгуулахаар газрын асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт ирүүлснийг Хэрлэн сумын 2026 оны Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулахаар шилжүүлсэн. | 100 | 100.00 |
| 120 | 3.2.4.3.2. "Ахуйн үйлчилгээ" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах. | 10.0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | "Ахуй үйлчилгээний өдөрлөг", "Зүүн бүсийн үсчин гоо засалчдын тэмцээн"-ийг зохион байгуулсан | 1 | 2025 оны 03 сард Зүүн бүсийн нийтийн ахуйн үйлчилгээний салбарын анхдугаар чуулганыг зохион байгуулж, мэргэжлийн байгууллагын ур чадвар олгох, чадавхжуулах сургалт хийж Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн 230 гаруй ахуйн үйлчилгээний салбарын ажиллагсдыг хамруулсан. Аймгийн ахуйн үйлчилгээний салбарт ажиллагсдыг чадавхжуулах, ур чадвар олгох зорилготой “Нийтийн ахуйн үйлчилгээ 2025” нэгдсэн арга хэмжээг | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 10 дугаар сарын 28-нд зохион байгуулж 12 сум, 1 тосгоны 60 гаруй үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид сургалт, ур чадварын тэмцээнд оролцож, шилдгүүдээ шалгаруулан, харилцан туршлага солилцож ажиллалаа. | | |
| **3.2.5. “Атар IV” аян, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| **3.2.5.1. “Атар IV” аяны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.** | | | | | | | | |
| 121 | 3.2.5.1.1. Хаврын тариалалт болон намрын ургацын баланс тогтоох, тариалангийн бүс нутагт хяналт шалгалтаар ажиллах | 2.0 | Хяналт хийсэн сумдын тоогоор | 9 сумын 35 аж ахуйн нэгжийн 19 мян.гад хяналт шалгалт хийсэн. | 10-с доошгүй сумдад ажилласан байна. | 2025 оны 06 болон 08 дугаар сард 10 сумын 2 иргэн, 22 аж ахуйн нэгжийн 19.1 мянган га тариалангийн талбайд хаврын тариалалт болон намрын ургацын баланс тогтоох хяналт шалгалтыг хийсэн. | 100 | 100.00 |
| 122 | 3.2.5.1.2. Атаршсан 5.0 мянган га талбайг эргэлтэд оруулах. | - | эргэлтэд оруулсан талбайн хэмжээ га | 2987 га тариалангийн талбайг эргэлтэд оруулсан. | 1250 га-гаас доошгүй атаршсан тариалангийн талбайг эргэлтэд оруулна. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний 166 дугаар тогтоолоор тус аймгийн Баянхутаг, Биндэр, Баян-Овоо, Баян-Адарга сумдын 2130.2 га атар газрыг тариалангийн талбайд шилжүүлсэн. 2025 оны 12 дугаар сарын 04-ны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 9 дүгээр хуралдааны 4 дүгээр тогтоолоор Баянмөнх, Жаргалтхаан сумдын 4 байршилд 1513.4 га атар газрыг тариалангийн талбайд шилжүүлэхээр | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баталсан. Мөн 12 дугаар сарын 22-нд болох аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 10 дугаар хуралдаанд Цэнхэрмандал сумын 1560 га атаршсан талбайг тариалангийн эргэлтэд оруулах асуудлыг хэлэлцүүлэхээр уламжилсан. Нийт 5203.6 га талбайг эргэлтэд оруулж байна. 12 суманд 386.6 га атаршсан талбайг хоршоодод олгож эргэлтэд оруулснаар ногоон тэжээлийн тариалалт нэмэгдэж 450 тн ургац хураан авсан. | | |
| 123 | 3.2.5.1.3. Тариалангийн талбайн хөрс хамгаалах тэг элдэншүүлгийн болон цомхотгосон технологийг нэвтрүүлэх | - | нэвтрүүлсэн Га-гаар | 50га-д тэг элдэншүүлгийн болон цомхотгосон технологийг нэвтрүүлсэн | 100 га-д нэвтрүүлсэн байна. | Тариалангийн талбайн хөрс хамгаалах тэг элдэншүүлгийн болон цомхотгосон технологийг нэвтрүүлэх зорилгоор Хэрлэн сумын "Хэнтий тариалан" ХХК нь 300 га-д улаанбуудай, арвайн холимог тариалалт хийж 300 тн ургац хураан авсан. | 100 | 100.00 |
| 124 | 3.2.5.1.4. Тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах | - | Үр тарианы хамгаалалтын ойн зурвас байгуулсан га-аар | Нийт 13.6 га тариалангийн талбайд зурвас байгуулсан. | 100 га-д хамгаалалтын зурвас байгуулсан байна. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тариалангийн талбайн хөрс хамгаалах зорилгоор Өмнөдэлгэр сумын "Явын булаг" хоршоо, Хэрлэн сумын "М-Агро" ХХК, Гурванбаян тосгоны "Агро импекс" ХХК-д нь нийт 80 га-д 14000 ширхэг мод тариалж ойн зурвас байгуулсан. | 80 | 76.80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны худалдан авах гэрээнд нэмэлт өөрчлөлт орсноор энэ онд тэжээлийн тарималыг нэмэгдүүлэх зорилгоор тус аймагт 4 төрлийн 11.2 тн буюу 53.0 сая төгрөгийн тэжээлийн үр олгож, Өлзийт тосгоны "Эй, Эс поржект" ХХК-д хошуу будааны 7 тн үрийг 2 жилийн хугацаатай зээлийн гэрээ байгуулж олгосон. Үлдсэн 4.2 тн тэжээлийн үрийг ирэх хаврын тариалалтад нөөцөлсөн. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 04-ний А/688 тушаалаар 80 хувийн хөнгөлөлттэй супер элит 9.0 тн төмсний үрийг 5 сумын үр үржүүлэгч 29 ногоочинд олгож, "Усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд 8 сумын 56 ногоочин 100 кг 6 төрлийн ногооны үрийг үнэгүй олгосон. | | |
| 125 | 3.2.5.1.5. Хоршоо, иргэн, аж ахуйн нэгж, ногоочдод хөнгөлөлттэй үрийн дэмжлэг үзүүлэх | 15.0 | дэмжлэг үзүүлсэн хоршоо, иргэн, аж ахуйн нэгжийн тоогоор. | 750 иргэн, аж ахуйн нэгжид 8 нэр төрлийн төмс, хүнсний ногооны 21.2 тн хөнгөлөлттэй үрийн дэмжлэг үзүүлсэн. | 750-аас багагүй иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлнэ. | | 100 | 0.00 |
| 126 | 3.2.5.1.6. Хэрлэн суманд услалтын систем шинээр байгуулах. | - | Гүйцэтгэлийн хувиар | Услалтын системийн барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. | Услалтын системийн барилга угсралтын ажил 90 хувьд хүргэсэн байна. | Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд хэрэгжиж буй 700 | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | га-гийн усалтын системийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Жинсийн орой" ХХК ажиллаж байгаа бөгөөд энэ онд цахилгааны эх үүсвэр, угсралтын ажил бүрэн хийгдэж дууссанаар нийт ажлын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна. | | |
| 127 | 3.2.5.1.7. Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | - | дэмжлэг үзүүлсэн тоогоор | 36 зуны хүлэмж ашиглалтад орсон. | Өвөл зуны хүлэмж байгуулахад дэмжлэг үзүүлнэ | Бор-Өндөр суманд хоршоо хөгжүүлэх сангаас "Баялаг бат өндөр тэгэл" хоршоонд өвлийн хүлэмж байгуулах чиглэлээр 80.0 сая төгрөгийн зээл олгосон. | 100 | 100.00 |
| 128 | 3.2.5.1.8. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалт, зөвлөгөөн зохион байгуулах. | 7.0 | Сургалтад хамрагдсан хүний тоогоор | Улсын болон аймгийн хэмжээний анхан шатны сургалтад давхардсан тоогоор 120 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. | 100-аас доошгүй тариалан эрхлэгчдийг сургалт, зөвлөгөөнд хамруулсан байна. | Төрөөс хэрэгжүүлж байгаа газар тариалангийн бодлого зорилтыг бүсийн хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор “Бүсчилсэн хөгжил-Тогтвортой газар тариалан 2025” тариаланчдын нэгдсэн зөвлөгөөн, сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр амжилттай зохион байгуулж, Дорнод, Сүхбаатар аймгийн газар тариалан эрхлэгчдийн төлөөлөл болон аймгийн 18 сум, 2 тосгоны 160 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцсон. | 100 | 100.00 |
| 129 | 3.2.5.1.9. Сумдын хөдөө аж ахуйн мэргэжилтний чадавх сайжруулах сургалт зохион байгуулах. | 4.0 | Сургалтад хамрагдсан хүний тоогоор | 30 мэргэжилтэн хамрагдсан | 36 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт төрөөс хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан салбарын бодлого арга | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээг сум орон нутгийн бодлого төлөвлөлттэй уялдуулах, иргэд, малчид, тариаланчид, хоршоодыг салбарын мэдлэг мэдээллээр зөв хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэх, чадваржуулах зорилготой "Сумдын хөдөө аж ахуйн мэргэжилтнийг чадавхжуулах сургалт, зөвлөгөөн"-ийг 2025.05.08-ны өдөр зохион байгуулж, 16 сум, 5 тосгоны нийт 46 албан хаагчид тус зөвлөгөөнд оролцсон. Сумдын мэргэжилтнүүдэд хоршоо хөгжүүлэх сангийн журмын танилцуулга, зөвлөгөө мэдээллийг өгснөөр чанаргүй зээлийн эргэн төлөлтийг сайжруулж өнгөрсөн оноос зээл олголтыг 1 дахин нэмэгдүүлээд байна. | | |
| **3.2.5.2. Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг аюулгүй, чанартай бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | |
| 130 | 3.2.5.2.1. "Намрын баяр", "Цагаан сар-Цагаан идээ", "Өвлийн идэш" нэгдсэн арга хэмжээг жил бүр зохион байгуулах. | 15.0 | Зохион байгуулсан ажлын тоо, хамруулсан иргэн, аж ахуйн нэгжийн тоогоор. | "Хэнтийн намрын баяр", "Цагаан сар-Цагаан идээ", "Өвлийн идэш" нэгдсэн арга хэмжээнд 18 сум, 3 тосгоны 200 иргэн, 50 аж ахуйн нэгж, хоршоо хамрагдсан. | Арга хэмжээг зохион байгуулж 200-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна. | Үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжиж малчид, тариаланчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах, хүн амыг чанартай, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангах зорилгоор "Хэнтийн намрын баяр 2025", "Цагаан сар-Цагаан идээ 2025", "Өвлийн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | идэш-2025" нэгдсэн арга хэмжээг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 18 сум, 5 тосгоны үйлдвэрлэл эрхлэгчид 150 аж ахуйн нэгж, 370 иргэн 200 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 647.7 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. | | |
| 131 | 3.2.5.2.2. Төрийн байгууллагууд, томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчдээс хангах. | - | дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн хувиар | 1.2 тэрбум төгрөгийн буюу нийт дотоодын хүнсний бүтээгдэхүүний 6%-г нийлүүлсэн. | Нийлүүлэлтийн хэмжээг 5%-аар нэмэгдүүлсэн байна. | Аймгийн 18 сум, 5 тосгоны Эрүүл мэндийн төв, 27 ЕБС, 36 СӨБ, 5 уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид 1.3 тэрбум төгрөг, аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хоол үйлдвэрлэлд 81.0 сая төгрөг, нийт 1.4 тэрбум төгрөгийн төмс, хүнсний ногоо, мах, сүү, гурилан бүтээгдэхүүнийг орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгч 75 аж ахуй нэгж, 158 иргэнээс нийлүүлсэн ба энэ нь дотоодод үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 6%-ийг эзэлж байна. Борлуулалт өмнөх оноос 15 хувиар нэмэгдсэн. | 100 | 100.00 |
| 132 | 3.2.5.2.3. "Аварга тогооч, зөөгч шалгаруулах" ур чадварын тэмцээн зохион байгуулах. | 6.0 | Зохион байгуулсан ажлын тоо, хамруулсан иргэн аж ахуйн нэгжийн тоо | "Улсын аварга тогооч" шалгаруулах анхдугаар уралдаан болон аймгийн "Аварга тогооч шалгаруулах" ур чадварын тэмцээнд 40 | 1-ээс доошгүй арга хэмжээ зохион байгуулж 20-аас доошгүй хүнс, хоол үйлдвэрлэгч нарыг хамруулсан байна. | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт дэвшилтэт технологи нэвтрүүлэх, мэргэжлийн тогооч, зөөгч нарын ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, орон нутгийн брэнд хоол ундыг бий болгох зорилгоор | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. | | "Аварга тогооч, зөөгч шалгаруулах" ур чадварын тэмцээнд 14 сум 3 тосгоны 57 тогооч “Орчин үеийн Монгол хоол”, “Нутгийн брэнд хоол”, “Ресторан, зоогийн газар, кафе-н төрөл”, “Талх, нарийн боов”, “Цэцэрлэг”, “Сургууль”, “Эмнэл зүй”, “Тогоочийн мэргэжлээр суралцаж байгаа коллеж оюутан”, “Өглөөний цай”, “Жуулчны өглөөний цай”, “Зөөгч үйлчилгээний төрөл”, “Шилдэг багийн Гранпри” гэсэн 12 төрлийн тэмцээнээр өрсөлдөж шилдгүүдээ шалгаруууллаа. Говийн болон зүүн бүсийн аймгуудын аварга тогооч, зөөгч шалгаруулах “Буурч цом” ажил мэргэжлийн уралдаан, "Монгол улсын аварга тогооч, зөөгч-2025" ажил мэргэжлийн ур чадварын уралдаанд Хэнтий аймгийг төлөөлөн 18 тогооч оролцож 1 алт, 2 мөнгө, 6 хүрэл, 3 тусгай байрын шагналыг авлаа. | | |
| 133 | 3.2.5.2.4. Мал бэлтгэх, төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах, экспортлох, импортлоход тавигдах шаардлагыг хангуулах. | 8.0 | Хэрэгжилтийн хувиар | Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын хэрэгжилт 35 хувь байна. | 40% | Хүн амын хүнсний хэрэгцээг аюулгүй, чанартай мах, махан бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ХХААГ, МЭГ, ЭМГ, БОГ, ХХҮГ-ын улсын ахлах байцаагчид 08-34-02/056/01 дугаартай төлөвлөгөөт бус хяналт | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгалтын удирдамжийг баталж, хяналтад мал бэлтгэх, төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдаалах үйл ажиллагаа явуулж буй 14 объектийг хамруулсан. Хяналтаар нийт давхардсан тоогоор 367 зөрчил, дутагдлыг илрүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар чиглэл бүрээр нийт 287 заалт бүхий хугацаатай 22 албан шаардлага, улсын байцаагчийн 2 дүгнэлт үйлдсэн ба албан шаардлагын биелэлтийн хариуг 9 объект ирүүлсэн байна. Үүнээс 1 хуулийн этгээдэд зөрчлийн хэрэг нээж Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.2 дугаар зүйлийн 2 дахь заалтаар 5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтын хэрэгжилт 42% байна. | | |
| 134 | 3.2.5.2.5. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг ерөнхий чиг баримжаа олгох чадавхжуулах сургалтад хамруулах. | 8.0 | Сургалтад хамрагдсан хүний тоогоор | Сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, сургууль, | 200-аас доошгүй хүнийг сургалтад хамруулсан байна. | "Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал"-ын талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, 18 сум 2 тосгоны 80 гаруй хүнс үйлдвэрлэгч иргэн, аж | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | цэцэрлэг, эмнэлгийн тогооч нарт эрүүл ахуйн зохистой дадал мөрдүүлэх, чадавхжуулах сургалтад 55 иргэн, аж ахуйн нэгж, хоршоог хамруулсан. | | ахуйн нэгж, хоршоодын төлөөлөл оролцсон. Хоол үйлдвэрлэгчдэд орчин үеийн хоолны чиг хандлага, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар мэдлэг олгох сургалтад 14 сум 3 тосгоны 70 тогооч хамрагдсан. Мөн Монгол улсын мастер тогоочдын холбоо, Хэнтий аймгийн тогоочдын холбоотой хамтран тогооч бэлтгэх анхан шатны сургалт зохион байгуулж нийт 25 тогооч, "Зохистой хооллолт ба боловсрол", "Сүүний салбарын ерөнхий ойлголт ба анхан шатны боловсруулалт" сэдэвт цахим сургалтад сургууль, цэцэрлэг, эмнэлэг, аж ахуйн нэгжийн 30 тогооч хамрагдаж, энэ онд нийт 4 сургалт зохион байгуулагдаж давхардсан тоогоор 205 хүнийг хамруулсан. | | |
| **3.2.6. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжиж малын тоог чанарт шилжүүлж, бэлчээр ашиглалтыг сайжруулна.** | | | | | | | | |
| **3.2.6.1. Бүс нутгийн онцлогт тохирсон эрчимжсэн мал аж ахуйг дэмжинэ.** | | | | | | | | |
| 135 | 3.2.6.1.1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх. | - | Дэмжлэг үзүүлсэн иргэн, ААН-ийн тоо | 4 аж ахуйн нэгжид 399.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 1-ээс доошгүй иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ. | "Атар IV Тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ы хүрээнд: Норовлин сумын иргэн Н.Ариунбилэгт "Өсвөр үхэр бордох, тоног төхөөрөмж сайжруулах" зорилгоор 500.0 сая төгрөг, - **Хоршоо хөгжүүлэх сангаас:** Жаргалтхаан | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сумын "Хэдэн гялаан" хоршоо махны чиглэлийн хонины цөм сүргийн аж ахуй байгуулахаар 114.0 сая төгрөг, Галшар сумын "Өгөөмөр өөдлөх" ХХК сүүний чиглэлийн үхэр үржүүлэх чиглэлээр 60.0 сая төгрөг, Мах-сүүний үхрийн аж ахуй эрхлэх зориулалтаар Бор-Өндөр сумын "Зоост алаг" хоршоо 115.0 сая төгрөг, Батноров сумын "Булгийн хоршил" хоршоо 43.0 сая төгрөг, Өмнөдэлгэр сумын "Цэгцэрийн уудам тал" хоршоо 20.0 сая төгрөг,<br>- **Хаан банкны "Эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжих" төслөөс**: Өмнөдэлгэр сумын "Гоё алтай" ХХК махны чиглэлийн үхэр үржүүлэх чиглэлээр 130.0 сая төгрөгийн дэмжлэг тус тус авсан бөгөөд аймгийн хэмжээнд эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж нийт 2 аж ахуйн нэгж, 4 хоршоо, 1 малчинд 982.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. | | |
| 136 | 3.2.6.1.2. Туслах аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх. | - | Дэмжлэг үзүүлсэн иргэн, ААН-ийн тоо | 3 аж ахуйн нэгжид 267.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 2-оос доошгүй иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ. | "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд Норовлин сумын "Могойн гол өргөн арын өвөр" хоршоо нь тахианы аж ахуй эрхлэх зорилгоор 50.0 сая төгрөгийн санхүүжилт | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авч 500 толгой тахиа худалдан авснаар сумын өндөгний хэрэгцээг бүрэн хангаан ажиллаж байна. Мөн Хаан банкны "Эмэгтэйчүүдийн бизнесийг дэмжих" төслөөс Хэрлэн сумын "Баатар билэг" ХХК-д 100.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, өндөглөгч тахиа 800, бөдөн шувуу 200 толгой тус тус авч шувууны аж ахуйн үйл ажиллагааг дэмжсэн. Улсын чанартай 4 удаагийн үзэсгэлэн худалдаанд "Зөгийн аж ахуй" эрхлэгчдийг хамруулж бүтээгдэхүүн борлуулалт болон орлогыг нэмэгдүүлэх тал дээр дэмжиж ажилласан. | | |
| 137 | 3.2.6.1.3 Мал үржүүлэг технологийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх | 8.2 | хээлтүүлэгчийн тоогоор | - | иргэн, аж ахуй нэгжид 15 толгой хээлтүүлэгчээр дэмжлэг үзүүлнэ | "Тал нутгийн цагаан" хонины тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор ОНТ-ийн 8.2 сая төгрөгийн санхүүжилтээр 15 толгой хуц худалдан авч "Хэнтий цөм сүргийн салбар" нэгжид дэмжлэг үзүүлсэн. | 100 | 100.00 |
| 138 | 3.2.6.1.4.Малчид, саальчид, тариаланчдыг дэмжиж урамшуулах | 60.0 | урамшуулсан хүний тоогоор | 54 малчин, саальчин, тариаланчийг шагнаж урамшуулсан. | 49 | Аймгийн Засаг даргын 2019 оны А/646, 2022 оны А/582 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу "Аймгийн аварга малчин"-аар 38 малчин, "Аймгийн аварга саальчин"-аар 6 саальчин, "Аймгийн аварга тариаланч"-аар 2 тариаланчыг тус тус | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгаруулж, шагнаж урамшуулсан. Мөн Монгол улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу “Улсын аварга малчин”-аар 8 малчин, “Алтан төл”-ийн эзнээр 4 малчин, "Улсын аварга тариаланч"-аар 1 тариаланчийг тус тус шагнаж урамшуулсан. | | |
| **3.3.6.2. Баталгаажсан үүлдэр, омгийн малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 139 | 3.2.6.2.1. "Дадалын Ухаа" үүлдрийн үхэрт үзлэг ангилалт хийх. | 6.3 | Ангилалтад хамрагдсан үхрийн тоо | 2.0 мянган үхэрт үзлэг ангилалт хийсэн. | 2.5 мянган үхэрт үзлэг ангилалт хийнэ. | Улс болон орон нутгийн төсвийн 26.3 сая төгрөгийн санхүүжилтээр Дадал сумын 4 багийн 150 малчин өрхийн Дадалын ухаа үүлдрийн 10.5 мянган толгой үхэрт үзлэг ангилалт хийж, 1.4 мянган толгой үхэр сүргийг ээмэгжүүлж, бүртгэлжүүлэн мэдээллийг малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан. | 100 | 100.00 |
| 140 | 3.2.6.2.2. Галшар үүлдрийн адуунд үзлэг ангилалт хийх ажлыг зохион байгуулах. | 5.0 | Ангилалтад хамрагдсан малын тоо | 2.0 мянган адуунд үзлэг ангилалт хийсэн. | 2.0 мянган адуунд үзлэг ангилалт хийнэ. | Орон нутгийн төсвийн 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр Галшар сумын 5 багийн 46 өрхийн Галшар үүлдрийн 4.3 мянган толгой адуунд үзлэг ангилалт хийсэн. | 100 | 100.00 |
| 141 | 3.2.6.2.3. Галшарын улаан "Омог"-ийн ямаанд үзлэг ангилалт хийх ажлыг зохион байгуулах. | 5.3 | Ангилалтад хамрагдсан малын тоо | 3.0 мянган ямаанд үзлэг ангилалт хийсэн. | 3.5 мянган ямаанд үзлэг ангилалт хийнэ. | ОНТ-ийн 10.9 сая төгрөгийн санхүүжилтээр Галшар сумын 5 багийн 24 өрхийн Галшарын улаан омгийн 7.0 мянган ямаанд үзлэг ангилалтыг хийж, 612 толгой ямааг ээмэгжүүлж, бүртгэлжүүлэн мэдээллийг | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан. | | |
| 142 | 3.2.6.2.4. “Тал нутгийн цагаан” үүлдрийн хонины тоо толгойг нэмэгдүүлж, үзлэг ангилалт хийх. | 0.3 | Ангилалтад хамрагдсан малын тоо | 200 толгой хонинд үзлэг ангилалт хийсэн. | 250 толгой хонинд үзлэг ангилалт хийнэ. | ОНТ-ийн 10.9 сая төгрөгийн санхүүжилтээр Галшар сумын 5 багийн 24 өрхийн Галшарын улаан омгийн 7.0 мянган ямаанд үзлэг ангилалтыг хийж, 612 толгой ямааг ээмэгжүүлж, бүртгэлжүүлэн мэдээллийг малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан. | 100 | 100.00 |
| | | | **3.2.6.3. Бэлчээрийг хамгаалж, нөхөн сэргээнэ.** | | | | | |
| 143 | 3.2.6.3.1. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулж, бэлчээрийг хамгаалах. | 15.0 | Хамгаалагдсан талбайн хэмжээ, га-гаар | 10 сумын 60.0 мянган га-д бэлчээрийн талбайд тэмцэх ажил хийсэн. | 6 сумын 30.0 мянган га-д хийнэ | Орон нутгийн төсвийн 17.5 сая төгрөгийн санхүүжилтээр Батноров, Жаргалтхаан, Баянмөнх, Дархан сумдад 32.0 мянган га талбайд бэлчээрийн хортон, мэрэгчтэй тэмцэх зорилгоор 20.0 мянган га талбайд 15 ширхэг шувууны үүр 85 ширхэг шувууны суудал, 12.0 мянган га талбайд ус цутгах, хөөө сугалах зэргээр энгийн механик аргаар бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулсан. | 100 | 100.00 |
| 144 | 3.2.6.3.2. Тал хээрийн бүсийн сумдад инженерийн хийцтэй худаг гаргах | - | Шинээр гаргасан худгийн тоогоор. | 31 гүн өрмийн худаг гаргасан. | 10-аас доошгүй инженерийн хийцтэй худаг гаргасан байна. | Улсын төсвийн 89.7 сая төгрөгийн хөрөнгөөр инженерийн хийцтэй 3 худаг, орон нутгийн төсвийн 249.5 сая төгрөгийн хөрөнгөөр 13 худаг, төсөл хөтөлбөрөөр 101,5 сая төгрөгөөр 6 худаг, малчдын санхүүжилт болон бусад эх үүсвэрийн 58.0 сая | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн хөрөнгөөр 5 худаг, нийт 498.7 сая төгрөгийн хөрөнгөөр 12 суманд 27 худаг шинээр гаргаж 40.5 мянган га бэлчээрийн талбайг усжуулсан. | | |
| 145 | 3.2.6.3.3. Аймгийн аюулгүй нөөцийн өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлнэ. | 100.0 | Гүйцэтгэлийн хувиар | Засгийн газрын тогтоолоор Аюулгүйн нөөцөд өвс, тэжээлийг 86.3 хувтай бэлтгэсэн. | Аюулгүйн нөөцөд өвс, тэжээл бэлдсэн байна. | Аймгийн аюулгүй нөөцийн өвс, тэжээл бүрдүүлэх зорилгоор бүдүүн тэжээл 78 тн, хүчит тэжээл 68 тн, эрдэс тэжээл 0.11 тн худалдан авах 3 багц, 69.4 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг 3 дахь удаагаа зарлаж Эрмэг транспорт ХХК, Баян-Эрдэс ХХК-тай гэрээ байгуулагдаж, нийлүүлэлт хийгдэж эхлээд байна. | 90 | 100.00 |
| **3.2.7. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, мал, малын гаралтай хүнсний түүхий эд бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | |
| **3.2.7.2. Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, мах, сүүнд анхан шатны шинжилгээ хийх мал эмнэлгийн нэгдсэн төвийг сумдад байгуулах.** | | | | | | | | |
| 146 | 3.2.7.2.1. 110 Малын эмчийн мэргэжлийн чадавхи сайжруулах сургалт зохион байгуулах. | 3.0 | Сургалтад хамрагдсан малын эмчийн тоо | 12 | 27 | Аймгийн Мал эмнэлгийн газар, Малын эмчийн итгэмжлэл, Мал аж ахуй ЭЗЭН төсөлтэй хамтран мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг дэмжих, Зүүн бүсийн малын эмч нарт хийх “гематологи-биохими, дүрс оношилгоо, эмчилгээ", Үхрийн фермийн үржүүлэг, хурдан морины сургалтыг зохион байгуулж 12 сумын 17 малын эмч мэргэжилтнүүд хамрагдсан. Мөн аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан малын эмч | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нарын зөвлөгөөн, төрөлжсөн чадавхжуулах сургалтад 110 малын эмч мэргэжилтэн хамрагдсан. "Мал эмнэлгийн чухал асуудлууд-2025" зүүн бүсийн зөвлөгөөнийг Дадал суманд 2025 оны 8 дугаар сарын 19-нд зохион байгуулж 7 аймаг болон өөрийн аймгийн 8 сумын нийт 180 гаруй малын эмч, мэргэжилтэн, албан хаагчид оролцсон. | | |
| **3.2.7.3. Мал, амьтны халдварт өвчний голомт, шимэгчтэх өвчний гаралт, тархалтыг бууруулж, зарим халдварт өвчний байгалийн халдварлалтыг тогтоох.** | | | | | | | | |
| 147 | 3.2.7.3.1. Гоц халдварт, халдварт өвчний голомтыг тоог бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх. | 793.1 | голомтын тоо | 17 | 12 | Гоц халдварт, халдварт өвчний голомтыг тоог бууруулах зорилгоор 18 сумын 72 аж ахуй нэгж халдваргүйтгэлийн арга хэмжээг 04 дүгээр сараас 11 дүгээр сарын 15-ны хугацаад хэрэгжүүлж, зоорь агуулах, хашаа хороон, худаг уст цэг, нийтийн эзэмшлийн талбай, махны үйлдвэр, голомтын болон устгалын цэг, шувуу, гахайн байр, өтөг бууц, бэлчээрийн талбайн нийт 910.9 м2 талбайг 3 төрлийн 1461 кг халдваргүйтгэлийн бодисоор халдваргүйжүүлж, гүйцэтгэл 91,4 %-тай ажилласан. 2025 онд аймгийн хэмжээнд гоц халдварт өвчний гаралт гахайн африкийн мялзан | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өвчин 2 голомт, хонины цэцэг өвчин 4 голомт, шүлхий өвчин 3 голомт, нийт 9 голомтод бүртгэгдсэн бөгөөд өвчний голомтын тоо өмнөх оноос 18.1%-аар буурсан. | | |
| 148 | 3.2.7.3.2. Жил бүр 3 сумандаа 3 төрлийн гоц халдварт өвчний байгалийн халдварыг тогтоох | 8.0 | Халдварлалт тогтоосон сумын тоо | 0 | 3 | Шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг өвчний байгалийн халдвар илрүүлэх тандалтын судалгаанд давхардсан тоогоор 28 сумын 79 өрхийн 1452 малыг хамруулж, дээж авч идэвхтэй тандалт хийсэн. Халдвар тогтоох тандалтын дүнгээр 9 суманд шүлхий өвчний халдвар байж болзошгүй дүн гарсан. Иймд аймгийн хэмжээний бүх үхэр, гахайг дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж, эрсдэл өндөр 6 сумын 37.3 мянган бог малыг яаралтай дархлаажуулалтад хамруулж ажиллалаа. | 100 | 100.00 |
| 149 | 3.2.7.3.3. Жил бүр нийт малын 80%-г шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах | - | Хамруулсан малын нийт малд эзлэх хувь | 79.5 | 80% хүртэл | Мал амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2025 оны А/180 дугаар захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны А/15 тоот тушаалаар аймгийн хэмжээнд малыг угаалга, боловсруулалт, туулгалтад хамруулах арга хэмжээг | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулж, нийт 3398.3 мян.мал хамргдахаас 3249.3 мянган мал хамруулж 93.4%-ийн гүйцэтгэлтэй ажиллалаа. Тус арга хэмжээний үр дүнд малын өвчлөлийн тархалт өмнөх оноос 10.5 %-иар буурсан. | | |
| **3.2.7.4. Малаас хүнд халдварладаг архаг халдварт бруцеллёз өвчнөөр эрүүл сум, баг, малчин өрхийг баталгаажуулж, эрүүл бүсийг бий болгох.** | | | | | | | | |
| 150 | 3.2.7.4.1. Бруцеллёз өвчингүй эрүүл сум, баг, малчин өрхийг баталгаажуулах | 150.0 | сумын тоогоор | - | 2 | Малаас хүнд халдварладаг архаг халдварт бруцеллёз өвчнөөр эрүүл сум, баг, малчин өрхийг баталгаажуулах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/599 дугаар захирамжийн дагуу Батширээт, Дадал сумдын үхэр сүргийг бруцеллёз өвчнөөр эрүүл болохыг баталгаажуулах ажлыг эхлүүлж Батширээт сумын 298 өрхийн 8459 мал, Дадал сумын 265 өрхийн 7655 малаас тус тус шинжилгээний дээж цуглуулсан. Тус дээжийг Мал эмнэлгийн лабораторид шинжилж байгаа бөгөөд урьдчилсан байдлаар нийт 8000 дээжид хийсэн шинжилгээгээр 22 үхрийн дээж эерэг гараад байна. Шинжилгээний ажлын гүйцэтгэл 40%-тай үргэлжилж байгаа бөгөөд 12-р сарын 15-ны өдрийн дотор дууна. | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.2.8. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартыг сайжруулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| **3.2.8.1. “Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 2030” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.** | | | | | | | | |
| 151 | 3.2.8.1.1. "Тогорууны баяр" эвент зохион байгуулах | 5.0 | хувь | 1220 жуулчин | Жуулчдын тоог өмнөх оныхоос 10 хувиар нэмэгдүүлсэн байна | Түүхэн аялал жуулчлалын бүс нутгийн байгаль, соёлын өвийг сурталчлах, Монголд болон дэлхийд ховордож буй цэн тогоруу, ус намгархаг газрын хамгаалалтыг нутгийн иргэдтэй хамтран сайжруулах зорилго бүхий “Тогорууны баяр” арга хэмжээ 2025 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Биндэр сумын “Цагаан нуур”-т зохион байгуулагдаж Герман, БНХАУ, Япон, Австрали зэрэг улс орны аялагч, шувуу судлаач, сонирхогчдоос гадна дотоодын 1500 гаруй иргэд үзсэн үзсэн нь өмнөх оныхоос 12 хувиар өссөн байна. Энэ үеэр хурдан морины уралдаан, Сурын харваа, хүүхдийн сурын харваа, Тогорууны зургийн уралдаан, Тогорууны бүжиг, шагайн харваа, бүжгийн тэмцээн зэрэг 7 уралдаан тэмцээн зохион байгуулагдсаны зэрэгцээ үе уламжлагдаж ирсэн үнэт бүтээл, түүхийн чухал үзмэрүүдээр гэр музейг тохижуулж гадаад болон дотоодын 200 гаруй жуулчдад танилцуулж сурталчилсан. Энэ арга | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээнд зориулсан 5 сая төгрөгийг зохион байгуулалтад зарцуулсан. | | |
| 152 | 3.2.8.1.2. "Талын түмэн адуу" эвент зохион байгуулах | 20.0 | хувь | дотоод гадаадын 20000гаруй жуулчид ирсэн | Жуулчдын тоог өмнөх оныхоос 10%-аар нэмэгдүүлсэн байна | Адуу дагасан соёлыг сурталчлах, орон нутагт өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зэрэг олон зорилгын хүрээнд "Талын түмэн адуу" өвлийн эвентийг 11 дэх удаагаа 2025 оны 11 сарын 21-23-ний өдрүүдэд Чингис хотод амжилттай зохион байгуулсан.<br>Тус эвентийн үеэр адуун соёлыг таниулсан, адуучин залууст зориулсан уралдаан тэмцээн, үзэсгэлэн, урлаг соёлын үйл ажиллагаа, музейн боловсролын хөтөлбөр зэрэг 11 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж 18 аймгийн адуучин залуусын төлөөлөл оролцож, 24 улсын 100 гаруй гадаадын жуулчид, дотоодын 21000 гаруй аялагч, жуулчин, иргэд үзэж сонирхсоноор нийтдээ 22,000 гаруй иргэд үзэж сонирхсон статистик гараад байна. Энэ нь өмнөх оныхоос 10 хувиар өссөн байна. Энэхүү эвентийг зохион байгуулахад төрийн болон төрийн бус байгууллагын 200 гаруй | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан хаагчид ажиллаж, нийт 150 гаруй сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулагдсанаас шагнал урамшуулалд 50 гаруй сая төгрөгийг зарцуулсан. | | |
| 153 | 3.2.8.1.3. "Ёохор" наадам зохион байгуулах | 10.0 | хувь | 2023 оны байдлаар дотоод гадаадын 1000 жуулчин үзэж сонирхсон байна | + | Түүхэн аялал жуулчлалын бүс нутгийг сурталчлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг өргөжүүлэх, Буриад угсаа нийтлэгийн соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий "Ёохор хатар-2025" наадмыг 2025 оны 07 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд Батширээт суманд зохион байгуулсан. Тус наадмын үеэр "Ёохор хатар" бүжгийн уралдаан, "Хатар жороо" морины уралдаан, "Посторной" богино зайн боосоот уралдаан, Буриад сурын харваа, Буриад бөхийн барилдаан, Сээр шалгах тэмцээн, Аялгата Буряад хэлэмнэй" уран уншлагын уралдаан зэрэг 7 төрлийн тэмцээн 2 өдрийн турш зохион байгуулагдаж ОХУ, Монгол 2 улсын 8 аймгийн 363 оролцогч оролцож гадаадын 45, дотоодын 2500 орчим иргэд үзэж буриад түмний соёл, ёс уламжлалтай танилцсан. Энэ нь өмнөх арга | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээнээс 25 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тус арга хэмжээг зохион байгуулахад аймгийн Засаг даргын зүгээс 18.0 сая төгрөгийн шийдвэрлэж наадмын зохион байгуулалт, шагнал урамшуулалд зарцуулсан | | |
| 154 | 3.2.8.1.4. Монгол хатад эвент арга хэмжээ зохион байгуулах | 5.0 | хувь | 500 гаруй жуулчид ирсэн | + | Монгол улсын түүхэнд эмэгтэйчүүд, хатдын оруулсан оролцоо, гавьяа зүтгэлийг алдаршуулах, сурталчлах, үндэсний өв соёл, уламжлал, заншлыг хүүхэд залууст түгээн дэлгэрүүлэх, сургах, эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоо, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, нутгийн иргэдийн бизнесийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор 3 жилд нэг удаа зохион байгуулагддаг "Монгол хатад" гуравдугаар наадмыг 2025 оны 08 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Баян-Адарга сумын нутаг, "Монгол хатдын өргөө" цогцолборт 11 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, дотоодын 2000 орчим иргэд, гадаадын 6 жуулчин үзэж сонирхсон байна. Энэ нь 2022 оныхоос 40 хувиар өссөн байна. | 100 | 100.00 |
| 155 | 3.2.8.1.5. Зочид буудал, жуулчны бааз, ресторaны 200-с доошгүй удирдлага, | 5.0 | сургалтад хамрагдсан ажилтны тоо | 200 хүнд сургалт хийсэн | Жилд 50-с доошгүй ажилчдыг | Монголын зочид буудлуудын холбоо, Зочлох үйлчилгээний холбоотой | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний ажилтныг чадавхжуулах сургалтад хамруулах | | | | сургалтад хамруулна | хамтран Хэнтий аймагт зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, жуулчны бааз, ресторан, кофе шопын ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан. Энэхүү зочлох үйлчилгээний ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэл бүхий 7 сэдвийн 8 цагийн багц сургалтад 8 сумын 70 гаруй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын удирдлага албан хаагчид хамрагдаж, сертификат олгосон. | | |
| 156 | 3.2.8.1.6. Зочлох үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуй нэгжүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | 5.0 | зөвлөгөө үзүүлсэн аж ахуйн нэгжийн тоо | 30 гаруй жуулчны баз 10 гаруй зочид буудал | 20-оос доошгүй | Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 8 сарын 22-ний өдрийн А/474 тоот захирамжаар батлагдсан ажлын хэсэг Жаргалтхаан, Цэнхэрмандал, Мөрөн, Дэлгэрхаан, Хэрлэн зэрэг 5 суманд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, жуулчны бааз, гэр буудал, дэн буудлын 21 аж ахуй нэгж байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг Онцгой байдлын газар, Стандарт, хэмжил зүйн газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын хяналтын байцаагч нартай хамтран 2025 оны 09 дүгээр сарын 3-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн хооронд зохион байгуулж, зөрчил дутагдлыг илрүүлэн ажилласан. | | |
| 157 | 3.2.8.1.7. Аймгийн аялал жуулчлал, түүх соёл, зан заншил, онцлог давуу талуудыг иргэд, олон нийт, жуулчдад сурталчлан таниулах брошур танилцуулга хэвлүүлэх | 5.0 | брошурын тоо | 1000 ширхэг | 1000 ш брошур хэвлүүлэх | Хэнтий аймгийн аялал жуулчлалын салбарыг таниулах, жуулчид аялагчдыг мэдээллээр хангах зорилгоор байгаль, соёлын өв, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог давуу тал, аялал жуулчлалын эвент, арга хэмжээ, түүхэн аялал жуулчлалын цогцолборуудын танилцуулга, зочлох үйлчилгээний салбарын сурталчилгаа, аяллын маршрут зэрэг 8 төрлийн мэдээлэл бүхий брошур танилцуулгын эхийг шинэчлэн бэлтгэж, Эм Пи Эм ХХК-нд 1000 хувийг 5 сая төгрөгөөр хэвлүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгсөн. Энэхүү брошюрыг Хэнтий аймгийн сурталчлах зорилгоор зохион байгуулагдсан олон улсын 2 томоохон үзэсгэлэнгийн үеэр иргэдэд өгч орон нутгаа сурталчлахад зориулсан. | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 158 | 3.2.8.1.8. Нэг жуулчин-Нэг унага эвент арга хэмжээг шинээр зохион байгуулж жуулчдын урсгалыг нэмэгдүүлнэ | 20.0 | ирсэн жуулчдын тоо | + | 300-аас доошгүй | Талын түмэн адуу-2025" өвлийн эвент, Ёохор хатар-2025, Галшар Адууны баяр зэрэг арга хэмжээнүүдийн үеэр "Нэг жуулчин - Нэг унага" арга хэмжээг зохион байгуулж Солонгос, Герман, АНУ, Япон, Румин, Филлипин, Тайван, Шинэ зеланд, БНХАУ, Австрали, ОХУ зэрэг 15 улсын 312 жуулчид ирж үзэн сонирхож 41 гадаадын жуулчинд малчдын адуун сүргээс унага бэлэглэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | 100 | 100.00 |
| 159 | 3.2.8.1.9. .Аялал жуулчлал гудамж төсөл хэрэгжүүлэх | 30,0 | хэрэгжилтийн хувиар | | 30% | Залуучуудын гэрэлт гудамж байгуулах зорилгоор 2025 оны 8 сарын 4-ний өдөр Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч нь "Тоонто гранд" ХХК-тай 20 сая төгрөгөөр гэрээ байгуулсан бөгөөд зураг төсвийг 2025 оны 12 сарын 3-нд хүлээж аваад байна. | 100 | 100.00 |
| 160 | 3.2.8.1.10. 9.27-ны Дэлхийн аялал жуулчлалын өдрийг угтаж аялал жуулчлалын салбарын байгууллагуудын уулзалт, урлаг спортын арга хэмжээг 2 жилд 1 удаа зохион байгуулах | 5,0 | Арга хэмжээнд оролцсон ажилчдын тоогоор | ДАЖ-ын өдрөөр 5 сургуулийн эко клубын 30-аад сурагчдад автобустай хотын аялал зохион байгуулсан | салбарын 150 ажилчдыг хамруулсан байна | Дэлхийн аялал жуулчлалын өдөр, Соёл урлагийн ажилтны 33 дахь өдрийг хамтран тэмдэглэх ажлын хүрээнд сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс зэрэг 3 төрөл тэмцээн зохион байгууллаа. Тус тэмцээнд аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг зочлох үйлчилгээний салбарын Ханбүргэд зочид буудал, Элит зочид буудал, Чингис | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зочид буудал, Элит эко жуулчны бааз, Хөвчийн Жонон ХХК, Монголын далд уурхайн музей зэрэг аж ахуй нэгжүүдээс 6 баг, соёл урлагийн салбарын 6 баг нийт 12 багийн 150 ажилтан албан хаагч амжилттай оролцсон ба спортын арга хэмжээнд аймаг орон нутгаас 8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | | |
| **3.2.8.2. Аялал жуулчлалын цогцолборуудыг эдийн засгийн эргэлтэд оруулна.** | | | | | | | | |
| 161 | 3.2.8.2.1. Их хуралдай цогцолборт олон улсын болон бүсийн хэмжээний хурал, семинар, сургалт уулзалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | - | арга хэмжээ зохион байгуулсан байна | Тус цогцолбор нь 2025 оны 06 дугаар сарын 22-ноос 9 дүгээр сарын 10 хүртэл ажиллах хугацаанд нэг арга хэмжээ зохион байгуулж нийт 8000 гаруй иргэдэд үзүүлж сурталчлан ажилласан. Үүнд: Ахмад настан 1220, том хүн 1905, хүүхэд 5000 гаруй, Биндэр сумын ЕБС-ийн 8-12-р ангийн 820 сурагч, багш эцэг эхийн төлөөлөл, гадаадын 50 жуулчин үзсэн байна. Их хуралдай цогцолборын үйл ажиллагааг эдийн засгийн эргэлтэд оруулах, ажиллах хүч, урсгал зардлын судалгааг гарган Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлсэн. | 100 | 100.00 |
| 162 | 3.2.8.2.2. Далд уурхайн музейг олон нийтэд сурталчилах, арга хэмжээ | 5.0 | дэмжлэг үзүүлсэн тоогоор | - | дэмжлэг үзүүлсэн байна | Бэрх хотод шинээр байгуулагдсан "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | | | | | жуулчлалын төв"-ийн үйл ажиллагааг дэмжих, музейг сурталчлах, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх хүрээнд төрийн албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр музей үзүүлэх ажлыг зохион байгуулж 16 байгууллагын 450 гаруй албан хаагч үзсэнээс гадна том хүн-12800, 16-18 насныхан – 2870, 6-16 нас хүртэлх хүүхэд 10 000 гаруй нийт 25670 хүн үзсэн байна. "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв"-ийн Мэдээллийн төвийг түшиглэн хөтөч тайлбарлагчийг бэлтгэх сургалт зохион байгуулж, сургалтад аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | | |
| 163 | 3.2.8.2.3. Аялал жуулчлалын Олон Улсын үзэсгэлэн /ITM, Ulaanbaatar travel expo/-д жил бүр оролцож, Зүүн бүсийн Түүхэн аялал жуулчлалын маршрутыг сурталчлах, түүхэн цогцолборуудын менежментийг сурталчилж, эдийн засгийн эргэлтэд оруулах | 10.0 | сурталчилгаа, мэдээлэл хүргэсэн хүний тоо | 2024 онд 10 аж ахуй нэгж оролцож, 3000 гаруй хүнд аймаг орон нутгаа сурталчилсан. | 3500 иргэн аж ахуй нэгж, тур операторууда д сурталчилж ажиллана | Улаанбаатар хотод 2025 оны 05 сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Ulaanbaatar travel expo" дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэнд 4 суманд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 4 байгууллагатай хамтран оролцсон ба орон нутгийн онцлог, аялал жуулчлалын үйл ажиллагаа, зочлох үйлчилгээг дотоод, гадаадын нийт 3500 гаруй | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэдэд сурталчилсан. Мөн Улаанбаатар хотод 2025 оны 10 дугаар сарын 24-26-ны өдөр зохион байгуулагдсан “Ай Ти Эм” олон улсын үзэсгэлэнд аялал жуулчлалын салбараас төлөөлөл болон оролцсон 9 аж ахуй нэгжид аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас 10,000,000 /Арван сая/ төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Тус үзэсгэлэнд Дуурлиг нарс, Чингисийн тоонот, Аварга тосон жүрж, Хүннү хөдөө арал, Талын түмэн адуу кемп, Их хуралдай цогцолбор, Тэнгэрийн нүүдэлчид, Тайга нохойтой морин аялал, Онон ширээт зэрэг 9 аж ахуй нэгж оролцож 48 тур оператор компанитай хамтран ажиллах гэрээ байгуулан 4000 гаруй дотоод, гадаадын жуулчдад аймаг орон нутгаа сурталчилсан. | | |
| 164 | 3.2.8.2.4. Түүхэн цогцолборуудаар бэлэг дурсгалын бүтээгдэхүүн гаргах төслийг хэрэгжүүлэх | 5.0 | бүтээгдэхүүний нэр төрлийн тоо | | 1 | Орон нутгийн онцлог, түүхэн аялал жуулчлалын бүс нутгийг сурталчлах, бэлэг дурсгалын бүтээгдэхүүний хүртээмж, нэр төрлийг олшруулах чиглэлээр жуулчдад зориулж, ханын календарь 100 ширхэг, ширээний календарь 100 ширхэг, | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөргөгчийн наалт 100 ширхгийг хэвлүүлж аймгийн Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгсөн. | | |
| **3.2.9.1. Орон нутгийн онцлогт тулгуурласан Улс, ОУ-ын чанартай эвент, наадмуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх** | | | | | | | | |
| 165 | 3.2.9.1.1 “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох | 20,0 | Шинээр оролцогчдын тоо | Нүүдэлчин соёлын фестивальд 45 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, соёлын биет бус өвийн 7 ай савын 362 төрөл зүйлийн 30 гаруй хөтөлбөрт оролцсон | 5-с доошгүй өвлөн уламжлагчдыг оролцуулна | Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг тодорхойлох, хадгалж хамгаалах, өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлах, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд 4 дэх жилдээ зохион байгуулагдсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль, соёлын биет бус өвийн их наадамд 2025 оны 8 дугаар сарын 22-24-ны өдрүүдэд зохион байгуулагдаж Хэнтий аймаг 55 хүний бүрэлдэхүүнтэй оролцож соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, өвлөн суралцагчид 5 төрөлд 7 өвлөн уламжлагч шилдгээр шалгарсан амжилт үзүүлсэн. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны зардлаас 20 сая төгрөгийг фестивальд оролцсон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын 4 өдрийн байр, хоолны зардалд зарцуулсан. | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.2.9.2. Аймаг, орон нутгаас төрөн гарсан урлаг, соёлын алдартнуудын уран бүтээлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлнэ** | | | | | | | | |
| 166 | 3.2.9.2.1 Уламжлал болгон зохион байгуулагддаг Л.Дашням, Б.Шарав нарын нэрэмжит улсын уралдаануудыг зохион байгуулах | 60,0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2023 онд зохион байгуулагдаж Бүжгийн уралдаанд 9 аймгийн 5 театр, 4 чуулгын 25 уран бүтээлч, Уртын дуу дуулаачдын уралдаанд 4 аймгийн 4 театр, 4 чуулга, ЕБС-ийн 138 сурагч, 41 уран бүтээлч оролцож байсан | Л.Дашнямын нэрэмжит дууны улсын уралдаан, Б.Шаравын “Сэрсэн тал” хөгжмийн бүтээлийн улсын уралдаануудыг зохион байгуулна. | Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Л.Дашнямын нэрэмжит “Жонон хонгор” дуу дуулаачдын Улсын уралдааныг Хэнтий аймгийн Чингис хотод 2025.05.15-16-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулга хамтран зохион байгуулж уралдаанд Улаанбаатар, Хөвсгөл, Сүхбаатар, Дорноговь, Дорнод, Хэнтий аймгуудаас нийт 60-аад оролцогчид хамрагдаж, шүүгчээр МУСГЗ Ч.Буянхишиг, МУГЖ Ц.Төвшинтөгс, МУГЖ С.Нансалмаа нар ажиллаж, мэргэжлийн, сонирхогчдын, хүүхдийн цөөхүүл гэсэн 3 ангилал тус бүрээр нийт 12 байр шалгаруулан Засаг даргын үйл ажиллагааны зардлаас 20 сая төгрөгийн санхүүжилт үзүүлж захирамжийг төлөвлөж тойруулан ажлын хэсэг байгуулан ажилласан. | 100 | 100.00 |
| 167 | 3.2.9.2.2 Иргэд олон нийтэд урлаг соёлын үйлчилгээ үзүүлэх стандартын шаардлага хангасан орчинг бүрдүүлэх | 309,2 | Гүйцэтгэлийн хувиар | Баянхутаг сумын соёлын төвийн засвар, Норовлин сумын соёлын төвийн барилга | 100 | Баянхутаг сумын Соёлын төвийн засвар 470 сая төгрөгөөр 2024 онд дуусаж, 2025 онд улсын комисс хүлээн авч үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Норовлин сумын Соёлын | | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвийн барилгыг улсын комисс хүлээн авч иргэдэд соёлын үйлчилгээг хэвийн явуулж байна. | | |
| **3.2.9.3. Соёлын өвийг сурталчилж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна** | | | | | | | | |
| 168 | 3.2.9.3.1 Соёлын биет бус өвийн суурь судалгаа, мэдээллийн санг баяжуулан баримтжуулах ажлыг зохион байгуулах | – | Хувиар | 799 СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг бүртгэсэн | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын 5-аас доошгүй хувийг баримтжуулна | Арга хэмжээний хүрээнд дараах ажлыг зохион байгуулав. Үүнд:<br>- Бурхан Халдун уул түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаатай хамтран Дэлхийн өвийн газар нутагт "Соёлын биет бус өв"-ийн судалгааны хүрээнд тухайн бүс нутгийн угсаатны бүлэг, ураг удам, нутагт орших соёлын биет бус өв, ёс заншил, зан үйлийг баримтжуулах зорилгоор Өмнөдэлгэр суманд 13, Батширээт суманд 9, Хэрлэн суманд 5 өвлөн уламжлагчдыг тус тус судалгаанд хамруулж гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулан ажилласан.<br>- Хан Хэнтий нутгийн эртнээс уламжлагдаж ирсэн өв соёлоо таньж мэдэх, орон нутгийн түүх, соёлын өвийг баримтжуулах, хадгалж хамгаалах зорилгоор аймгийн музейгээс Батширээт, Биндэр, Баян-Адарга сумдад нийт 19 Соёлын биет бус өв өвлөн уламжлагчдад дүрс бичлэгийн баримтжуулалт | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийсэн. Тайлант онд 46 өвлөн уламжлагч буюу нийт Соёлын биет бус өв өвлөн уламжлагчийн 5.7%-ийг өв үйлдэж буй үйл явцыг баримтжуулж байгууллагын пэйж хуудаст байршуулж олон нийтэд сурталчлах болон Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн Соёлын биет бус өвийн дэд системийг баяжуулан ажилласан. | | |
| 169 | 3.2.9.3.2 Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан, сурталчлах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 10 арга хэмжээ зохион байгуулж сурталчилсан | Хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сурталчлах арга хэмжээ зохион байгуулсан байна. | - "Соёлын өвийг хамгаалах тухай хууль"-ийн 8.1, 15.2 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор "Сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д 18 сумын нутагт орших 173 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг батлуулсан.<br>- Үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлалтын ажил-1, эрдэм шинжилгээний бага хурал-1, хэлэлцүүлэг-1, Зүүн бүсийн сургалт-1 нийт 4 томоохон арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран тус тус амжилттай зохион байгуулсан.<br>- Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гуравдугаар хавсралтаар баталсан "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам", Соёлын сайдын 2023 оны А/317 дугаар тушаал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/253 тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Хэнтий аймгийн Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого зохион байгуулах салбар комисс Хэнтий аймгийн 14 сумын Соёлын төвийн дэргэдэх Орон нутаг судлах музей, аймгийн музейн сан хөмрөгт тооллогыг зохион байгуулан ажиллаж, тооллогын явц 90.5%-тай үргэлжилж байна. | | |
| ЗОРИЛГО 3.3 БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | | |
| **3.3.1. Байгалийн унаган төрх, экосистемийн тогтвортой байдлыг хадгалж, биологийн олон янз байдлыг хамгаална.** | | | | | | | | |
| **3.3.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 170 | 3.3.1.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж, нийт нутаг дэвсгэрийн 48%-д хүргэнэ. | 1.0 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ аймгийн нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь | Улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нийт нутгийн 46.4 хувийг эзэлж байна. | 47.0% | Мөрөн сумын орон нутгийн хамгаалалттай Дэлгэр уул, Хатан уул, Түмэн өлзий уул, Чандман, Гамал зэрэг 4 газрын хамгаалалтын Мөрөн сумын орон нутгийн хамгаалалттай Дэлгэр уул, Хатан уул, Түмэн өлзий уул, Чандман, Гамал зэрэг хамгаалалтын хугацаа нь дууссан 4 газрыг 2050 он хүртэл хугацааг сунгасан. Мөн Монгол Улсын Засгийн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн "Байгалын нөөц болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох тухай" 106 дугаар тогтоолоор Дэлгэрхаан уулын байгалийн нөөц газрын 48447.15 га, Улз голын байгалийн нөөц газрын 102561 га, Хурах хүйтний хөндийн байгалийн нөөц газрын 208628 га газрын хилийг шинэчлэн тогтоож батлаcнаар аймгийн хэмжээнд Улсын тусгай хамгаалалттай газар 1441490.9 га, Орон нутгийн хамгаалалттай газар 2511289.08 га, нийт улс болон орон нутгийн хамгаалалттай газрын хэмжээ 3952779.98 га болж нийт нутаг дэвсгэрийн 49.2 хувийг эзэлж байна. | | |
| 171 | 3.3.1.1.2. Улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | 200.0 | Менежментийн төлөвлөгөө батлуулсан эсэх, хэрэгжилтийн хувь | Баян-Овоо сумын Хар ямаатын БНГ менежмент хэрэгжиж эхэлсэн | Дэлгэрхаан уул, Хэрлэн тооно уул, Тосон Хулстай, Улз голын БНГменежментийн төлөвлөгөөг батлуулна | Улсын тусгай хамгаалалттай Дэлгэрхаан уул, Хэрлэн тооно уул, Тосон Хулстай байгалийн нөөц газруудын менежментийн төлөвлөгөөг 10 жилийн хугацаатай боловсруулан БОУАӨСайдаар батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 90 хувьтай хэрэгжиж байна. | 90 | 100.00 |
| **3.3.1.2. Ховор амьтан ургамлыг өсгөн үржүүлж, хамгаалж, нөөцөд тохируулан тогтвортой ашиглана.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 172 | 3.3.1.2.1. Ашиглалтад өртөмтгий ховор ургамлын 2 төрөл зүйлийг 100 га -аас доошгүй талбайд тарьмалжуулна. | 50.0 | Ховор ургамал тарьсан талбайгаар, га | 3 зүйл ховор ургамал тарьмалжуулсан. | 25 га талбайд тарьмалжуулна | Дэлгэрхаан суманд "Астарүүтс" ХХК Дэрэвгэр жирэвгэрүү 100 га, Хунчир 50 га талбайд, Батноров суманд "Монголиан Сапошниковиа Дивариката" ХХК 38.6 га талбайд Дэрэвгэр жирэвгэрүү ургамлыг тус тус тарьмалжуулж, нийт 188.6 га талбайд 2 төрөл зүйл ховор ургамлыг тарималжуулсан. | 100 | 100.00 |
| 173 | 3.3.1.2.2. Ашиглалтад өртөмтгий амьтан 200-аас доошгүй толгойг сэргээн нутагшуулна. | 50.0 | Сэргээн нутагшуулсан амьтны тоогоор | ашиглалтад өртөмтгий амьтан 86 толгой нутагшуулсан | 50 толгой амьтан нутагшуулна. | Баянмөнх, Баян-Овоо, Батширээт сумд байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар 190 толгой, Дархан, Бор-Өндөр сумд дүйцүүлэн хамгааллаар 110 толгой, нийт 300 толгой "Монгол тарвага"-ыг сэргээн нутагшуулсан. | 100 | 100.00 |
| **3.3.1.3. Байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлж, олон нийтийн оролцоотой байгаль хамгааллыг сайжруулна.** | | | | | | | | |
| 174 | 3.3.1.3.1. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийг чадавхжуулах сургалтад хамруулна. | 15.0 | сургалтын тоогоор | 121 Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг 1 удаагийн сургалтад хамруулсан. | 1-ээс доошгүй удаа сургалт зохион байгуулна | Ойн газар, Онцгой байдлын газартай хамтран БНХМ-ийн 15 нөхөрлөлийн төлөөллийг ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулсан. Хөвсгөл аймагт зохион байгуулсан "Нөхөрлөл хөгжил" сургалт, үзэсгэлэн арга хэмжээнд 9 сумын БНХМ-ийн нөхөрлөлийн 200 гаруй гишүүдийг TNC олон улсын байгууллагын дэмжлэгээр оролцуулсан. | 100 | 100.00 |
| 175 | 3.3.1.3.2. Онон Балжийн БЦГ-т "Өвлөгдөн үлдэх газар | | төслийн тухайн жилийн | шинээр эхэлж байгаа | тухайн жилийн | Онон Балжийн БЦГ-т хэрэгжиж буй "Өвлөгдөн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нутаг" олон улсын төсөл хэрэгжүүлэх | | төлөвлөгөөний хэрэгжилтээр | | төлөвлөгөө хангагдсан байна. | үлдэх газар нутаг" олон улсын төслийн багтай хамтран гаргасан 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу ОББЦГ-ын орчны бүсийн зөвлөлийг чадавхжуулах сургалт, судалгаа, шинжилгээний ажил, техникийн дэмжлэг үзүүлэх ажил, орчны бүсийн сумдын ойн менежментийн төлөвлөгөөнд дахин шинжилгээ хийх, "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах болон хүлэмжийн хийг бууруулах оновчтой шийдлийг төлөвлөхөд орон нутагт тулгарч буй сорилт, даван туулах боломжуудыг тодорхойлох" сургалт, хэлэлцүүлэг, Онон-Балжийн ТХГ-ын менежментийн төлөвлөгөө болон орон нутгийн бусад холбогдох бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. | | |
| **3.3.1.4. Хариуцлагатай уул уурхайг бий болгох** | | | | | | | | |
| 176 | 3.3.1.4.1 Уул уурхайн нөлөөгөөр эвдрэлд орж орхигдсон 200 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх | 50.0 | нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ, га-аар | Жилд дунджаар нөхөн сэргээсэн талбай 30 га | 50 га | Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын хөрөнгөөр 2025 онд уул уурхай, дэд бүтцийн нөлөөгөөр эвдрэлд орж эзэнгүй орхигдсон Дархан сумын 15 га талбайг 20.0 сая төгрөгөөр, Бор-Өндөр сумын 5 га талбайг | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10.0 сая төгрөгөөр, Батноров сумын 6-р багийн нутаг дэвсгэрт 8.8 га талбайг аж ахуй нэгжийн 20.0 сая төгрөгөөр тус тус нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Тэгш плант ХХК-ийн авто замын барилгын ажилд ашиглагдсан түгээмэл тархацтай ашигт малтмалын карьер бүхий 41.6 га талбайд нөхөн сэргээлт хийлгэж хүлээж авсан. Нийт 70.4 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгүүлсэн. | | |
| **3.3.2. Ойгоор бүрхэгдсэн талбай, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, ойн нөөцийг хамгаална.** | | | | | | | | |
| **3.3.2.1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, "Гучин сая мод" арга хэмжээний хэрэгжилтийг хангана.** | | | | | | | | |
| 177 | 3.3.2.1.1. Бүх нийтээр мод тарих ажлыг ах зохион байгуулж нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. | 560.0 | Ногоон байгууламж нэмэгдүүлсэн талбайн хэмжээгээр, га | Ногоон байгууламжийн суурь судалгаагаар нийт 2019 га ногоон байгууламж бүртгэгдсэн. | Ногоон байгууламжийг 50 га -р нэмэгдүүлнэ. | Монгол улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 44 дүгээр зарлигийн хүрээнд хавар, намар 2 удаа бүх нийтээр "Тэрбум мод тарих өдрүүд" арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Мод тарих ажилд давхардсан тоогоор 13.7 мянган хүн, 2.8 мянган айл өрх, 160 аж ахуйн нэгж, байгууллага оролцож ногоон байгууламжид нийт 318.6 мянган мод тарьж, хот суурин газрын ногоон байгууламжийн талбайн хэмжээг Хэрлэн -1.7га, Батноров-9.5га, Баян-Овоо-8.0га, Баян-Адарга-5.4га, | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Бэрх-0.06га, Дархан-2.5га, Баянмөнх 2.5га, Галшар-2.5га, Норовлин-0.15га, Бор-Өндөр-18.0га, Биндэр-12.0га, Дэлгэрхаан-0.8га, Жаргалтхаан-1.0га, Мөрөн-1.5га, нийт 14 суманд 65.6 га-аар нэмэгдүүлсэн. | | |
| 178 | 3.3.2.1.2. Хот цэцэрлэгжүүлэлтийн зориулалтаар мод үржүүлгийн жишиг аж ахуй байгуулж, тарьц, суулгацыг нэмэгдүүлэх. | 100.0 | ажлын явц, гүйцэтгэлийн хувиар | сумдын 7 мод үржүүлгийн газар үйл ажиллагаа явуулж байна. | 20% /зураг төсөв хийлгэх/ | Улсын төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгөөр Хэрлэн суманд 10 га талбайд жишиг агро ойн аж ахуй, мод үржүүлгийн газар байгуулах саналыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт хүргүүлж, Ойн газраас ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг үндэслэн зураг төсөв боловсруулж батлуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан болович оролцогчгүйн улмаас цуцлагдсан ба улсын төсвийн тодотголоор хөрөнгө татагдсан. Боловсруулж батлуулсан ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг Эм Си Эс Групп-д хүргүүлж, хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллах санал хүргүүлээд байна. | 100 | 100.00 |
| 179 | 3.3.2.1.3. Сум, тосгодын төвийн ногоон байгууламжийн зураглал бүхий мэдээллийн санг жил бүр тодотгож, шинэчлэх | - | мэдээллийн сан шинэчлэгдсэн эсэх | 2022 онд суурь мэдээллийн сан хийгдсэн. | мэдээллийн санг шинэчилсэн байна. | Ногоон байгууламжийн мэдээллийн санд шинээр мод тарьсан 14 сумын 65.6 га талбайг нэмж бүртгэж, мэдээллийг шинэчилсэн. | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 180 | 3.3.2.1.4. Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, үйлдвэр аж ахуйн байгууллагын эзэмшил газрын 30-аас доошгүй хувьд нь ногоон байгууламж бий болгох /Эмнэлэг -24, Сургууль -28, Цэцэрлэг -33, Үйлдвэр -1 Нийт -90 байгууллагатай/ | - | мод тарьсан байгууллагын тоо, эзэмшил газарт ногоон байгууламжийн эзлэх хувь | * | 10 байгууллага газрынхаа 30 % д мод тарьж дуусгасан байна | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 18 сум, 5 тосгоны нийт 31 сургууль, цэцэрлэг, эмнэлэг, үйлдвэр уурхай хашаандаа мод тарих ажлыг зохион байгуулснаас 2025 онд эзэмшил газрынхаа 30-аас дээш хувьд мод тарьсан 14 байгууллага байна. | 100 | 100.00 |
| 181 | 3.3.2.1.5. Тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх /Жич: Усан сан, нуур цөөрөм, усны эх, булаг хамгаалах, мод үржүүлэг, нисэх онгоц, ус салхинаас хамгаалах зурвас, оршуулгын газар, цэвэрлэх байгууламж/ | 100.0 | Тусгай хэрэгцээний ногоон байгууламж нэмэгдүүлсэн талбайгаар | * | 100 га талбайгаар нэмэгдүүлнэ. | Голын татамыг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор Баян-Овоо суманд 3 га, Батширээт суманд 5.4 га, Дэлгэрхаан суманд 0.5 га, нийт 8.9 га талбайд бургасан ойжуулалт, хөрсний элэгдэл эвдрэл, цөлжилт, салхинаас хамгаалах зорилгоор Батноров суманд 9.5 га, Баян-Овоо суманд 8.0 га, Баян-Адарга суманд 5.4 га, Дархан суманд 2.5 га, Баянмөнх суманд 2.5 га, Галшар суманд 2.5 га, Норовлин суманд 0.15 га, Бор-Өндөр суманд 18.0 га, Биндэр суманд 12.0 га, Жаргалтхаан суманд 1.0 га, Өмнөдэлгэр, Хэрлэн, Гурванбаян тосгонд тариалангийн талбайн 80 га, Мөрөн суманд ногооны талбайн 3.0 га, нийт 144.5 га талбайд ойн зурвас, Бор-Өндөр сумын цэвэрлэх байгууламжийн орчны 2 га талбайд 15.8 мянган мод | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тарьж, нийт 155.4 га талбайд тусгай хэрэгцээний ногоон байгууламж шинээр бий болгосон. | | |
| 182 | 3.3.2.1.6. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайг төрийн бус байгууллага, нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр төлбөртэй хариуцуулж, арчилгааны асуудлыг шийдвэрлэж эзэнжүүлэх | | хариуцуулсан талбайн хэмжээг нийт нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн хэмжээнд харьцуулсан хэмжээ | - | 70% аас доошгүй талбайг хариуцуулсан байна. | "Нэг байгууллага - Нэг цэцэрлэг аян"-ы хүрээнд 18 сумын хэмжээнд төрийн болон төрийн өмчит байгууллагуудад нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг 100 хувь хариуцуулахаар хуваарилаж, мод тарих, арчилгаа усалгаа хийх ажлыг гүйцэтгүүлж, хяналт тавьж ажилласан. | 100 | 100.00 |
| 183 | 3.3.2.1.7. "Өрх бүр ногоон төгөл аян"-ыг хэрэгжүүлж хашаандаа мод тарьсан өрхийг урамшуулж жимсний мод бутны дэмжлэг үзүүлэх | 25.0 | Мод тарьсан өрхийн тоо | 3500 | 5000 | "Өрх бүр ногоон төгөл аян"-д 15 сумын 3.8 мянган өрх хамрагдаж 110.0 мянган мод бут сөөгийг хашаандаа тарьсан. Энэ онд аянд идэвхтэй хамрагдсан өрхүүдийг 2026 оны хаврын мод тарих улиралд урамшуулахаар 2026 оны төсөвт тусган батлуулсан. | 76 | 20.00 |
| 184 | 3.3.2.1.8. Ойн хомсдол доройтлыг бууруулах арга хэмжээний хүрээнд байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийх, ойг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх замаар нийт 10250 га талбайг ойжуулах | | Байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийсэн, ойжуулсан талбайн хэмжээгээр, га | 171 га-д ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 1840 га-д ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийнэ. | Доройтсон ойг нөхөн сэргээх ойжуулалтын ажлыг Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Өмнөдэлгэр суманд 20 га, Дадал суманд 20 га, Батширээт суманд 15 га, Норовлин суманд 1.0 га, нийт 56 га, Уул уурхайн компанийн хөрөнгөөр 23.7 га, Хаан банк өөрийн хөрөнгөөр 100 га, ойн мэргэжлийн байгууллагууд өөрийн хөрөнгөөр 214.3 га, | 20 | 13.80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орон нутгийн төсвийн хөрөнгөөр голын татамын доройтсон ойг хамгаалах, нөхөн сэргээх бургасан ойн ойжуулалт 3 суманд 8.9 га талбайд тус тус хийж, аймгийн хэмжээнд нийт 402.9 га талбайд ойжуулалт хийж 802.8 мянган тарьц тарьсан. Тус ажилд дээрх эх үүсвэрүүдээс нийт 1,322.9 сая төгрөг зарцуулж 335 хүнийг түр ажлын байраар хангасан. | | |
| **3.3.2.2. Ойн хөнөөлт шавжтай тэмцэж ойн хомсдол, доройтол, ой, хээрийн түймрийн эрсдэлийг бууруулна.** | | | | | | | | |
| 185 | 3.3.2.2.1. Тухайн жилд илэрсэн ойн хөнөөлт шавьжийн голомтын 50% -аас доошгүй талбайд тэмцлийн арга хэмжээг зохион байгуулах | 20.0 | Тэмцлийн ажил хийсэн талбайн хувиар | Нийт голомттой талбайн 64 хувьд тэмцэл хийсэн. | Голомттой талбайн 50 -аас доошгүй хувьд тэмцэл хийнэ. | Улсын төсвийн хөрөнгөөр Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал, Норовлин, Баян-Адарга сумдын нийт 32000 га, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Батширээт, Өмнөдэлгэр сумдын 5500 га, нийт 37500 га талбайд ойн хөнөөлт шавьжийн тэмцлийн ажил хийгдэж нийт голомттой талбайн 63.9 хувийг хамруулллаа. | 100 | 100.00 |
| 186 | 3.3.2.2.2. Ой хээрийн түймэртэй тэмцэх сургалт, сурталчилгаа хийх, цахимаар болон биечлэн мэдээлэл хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 5.0 | хамруулсан сумын тоо | Урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааг 18 сум, 5 тосгонд зохион байгуулсан. | 18 сум, 5 тосгон хамруулж мэдээллээр хангана. | Сум болон сум дундын ойн анги, 18 сумын байгаль хамгаалагч, багийн дарга нар ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг нэгдсэн сургалт, багийн өдөрлөгт оролцон тогтмол зохион байгуулж 12762 иргэнд анхааруулга санамж тараасан. Засгийн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газартай хамтран сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн нөхөрлөлийн гишүүд, ойн мэргэжлийн байгууллагын төлөөлөл зэрэг нийт 42 хүнд ой хээрийн түймэртэй тэмцэх сургалтыг зохион байгуулсан. Мөн аймгийн Засаг даргын нэрэмжит "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-ийг ОБГ-тай хамтран 18 сум 5 тосгонд зохион байгуулсан. | | |
| **3.3.3. Уур амьсгалын өөрчлөлт, байгаль, хүн үүрын гаралтай гамшигт үзэгдлийг эрт сэрэмжлүүлж, эрсдэлийг бууруулж, дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ.** | | | | | | | | |
| **3.3.3.1. Аймгийн "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах төлөвлөгөө"-г батлан хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| 187 | 3.3.3.1.1. Аймгийн "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах төлөвлөгөө"-г батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | | Хэрэгжилтийн хувиар | Төлөвлөгөөний төсөл бэлэн болсон | 10 | 3 стратеги чиглэл, 14 зорилтын хүрээнд 104 хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий аймгийн "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах төлөвлөгөө (2025-2030 он)"-г боловсруулж, аймгийн ИТХ-ын ээлжит 5 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, 6 дугаар тогтоолоор батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2025 оны А/269 захирамжаар батлуулж, энэ онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийг хариуцах агентлаг | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудад хүргүүлсэн. Төлөвлөгөөний хүрээнд Онон Балжийн БЦГ-т хэрэгжиж буй "Өвлөгдөн үлдэх газар нутаг" олон улсын төслийн багтай хамтран "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах болон хүлэмжийн хийг бууруулах оновчтой шийдлийг төлөвлөхөд орон нутагт тулгарч буй сорилт, даван туулах боломжуудыг тодорхойлох" сургалт, хэлэлцүүлгийг төсөл хэрэгжиж буй 4 сумыг хамруулан зохион байгуулж, сумын төлөвлөгөө боловсруулах ажилд зөвлөн тусалсан. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 104 арга хэмжээнээс энэ онд 38 арга хэмжээ 100 хувь хэрэгжиж, нийт хэрэгжилт 36.5 хувьтай байна. | | |
| **3.3.3.2. Ус, цаг уур, орчны хяналт, мониторингийн сүлжээний хүчин чадлыг сайжруулж, байгаль, цаг уурын гаралтай гамшигт үзэгдлээс эрт сэрэмжлүүлэх мэдээллийн төрөл, чанарыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 188 | 3.3.3.2.1. Гадаргын ус судлалын харуулын цэг сүлжээний хүчин чадлыг сайжруулж, мэдээллийн давтамжийг нэмэгдүүлэх | 10.0 | хүчин чадлыг сайжруулсан салбарын тоо, мэдээлэл дамжуулах тоо | 8 салбарын 1 салбарт автомат станц ажиллаж өдөрт 2 удаагийн түвшний мэдээлэл гардаг. | 1 салбарын хүчин чадлыг сайжруулж, өдөрт 24 удаагийн мэдээлэл дамжуулна. | Хэрлэн-Өндөрхаан ус судлалын харуулын цэг сүлжээний хүчин чадлыг сайжруулах хүрээнд усны түвшин, температур хэмжигч автомат багажийг улсын төсвийн 96.4 сая төгрөгийн хөрөнгөөр худалдан авч, ОНТ-ийн 2.8 сая төгрөгийн хөрөнгөөр | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суурилуулах ажлыг хийснээр усны харуулын мэдээллийг цаг тутамд буюу хоногт 24 цагийн давтамжаар авч, боловсруулж байна. | | |
| 189 | 3.3.3.2.2. Цаг агаарын гаралтай гамшигт болон аюултай үзэгдлийг эрт илрүүлэх, шуурхай удирдлагаар хангах "Шуурхай удирдлагын төв" бий болгож, урьдчилсан мэдээний таарцыг нэмэгдүүлэх | 36.0 | Цаг агаарын урьдчилсан мэдээний таарц, хувиар | Аюулт болон гамшигт үзэгдлийн таарц 88.6% | Таарц 90%д хүргэнэ | Цаг агаарын гаралтай гамшигт болон аюултай үзэгдлийг эрт илрүүлэх, шуурхай удирдлагаар хангах зорилгоор "Шуурхай удирдлагын төв" бий болгож аймгийн 16 сум 3 тосгоны цаг уурын салбар тус бүрт 270 градус эргэдэг камер суурилуулж, 4G холболтоор нэгтгэсэн. Салбарт нарны цахилгаан үүсгүүр, цахилгаан цэнэг хураагуураар төхөөрөмж суурилуулснаар цаг агаарын шуурхай мэдээ тасалдах, хоцрох нөхцөлийг арилгасан. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар аюулт болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээний таарцыг 93.4%-д хүргэж 4.8%-аар нэмэгдүүлсэн. | 100 | 100.00 |
| 190 | 3.3.3.2.3. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажиллагааг явуулах | 5.0 | Тунадас нэмэгдүүлсэн ажиллагааны тоо, үр дүн үнэлгээгээр | Жилд дунджаар 7-21 удаа үйлчилж үр дүнгийн үнэлгээгээр Маш сайн үнэлгээтэй ажиллаж байна. | Нөхцөл алдахгүй үйлчилж үр дүнг "Хангалтай" үнэлгээнд ажиллана | Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, 2 хөдөлгөөнт экспедици 21 процесст үйлчилж тунадас буух дэвсгэр нутгийн хэмжээг 20.3%, орох тунадасны хэмжээг 41.6%- | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иар тус тус нэмэгдүүлсэн. Нийт процесын 88,9%-д амжилттай үйлчилж "Хангалтай" үнэлгээнд ажилласан. Ой хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2 удаа, газар тариалангийн бүс нутагт 9, бэлчээрийн ургамлын ургалтад дэмжлэг үзүүлэхээр 11 удаа ажиллалаа. | | |
| 191 | 3.3.3.2.4. WEB SMS үйлчилгээг ашиглан цаг агаарын урьдчилсан мэдээг хүргэх | 8.0 | Мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо | 2024 онд 1 удаагийн мэдээллийг 3412 иргэнд хүргэж байна. Жилд дунджаар 9-19 удаа гамшигт болон аюулт үзэгдлийн мэдээллийг хүргэдэг | 1 удаагийн мэдээлэл хүргэх хэрэглэгчдийн тоог 5000 хүргэнэ. | Цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдлийн мэдээллийг 2025 онд 8649 хэрэглэгчдэд 21 удаагийн давтамжтайгаа WEB SMS үйлчилгээг ашиглан мессеж мэдээг хүргэсэн. Хэрлэгчдийн тоог өмнөх оноос 1 дахин нэмэгдүүлсэн. | 100 | 100.00 |
| 192 | 3.3.3.2.5. Суурин газрын агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого жил бүр хийх | 2.0 | Тооллогын ажлын үнэлгээгээр | Жил бүр Агаарын тухай хуулийн дагуу хийгддэг. Үнэлгээ "Хангалттай" үнэлэгдсэн. | 18 сум 3 тосгоны хэмжээнд тооллого хийж "Хангалттай" үнэлэгдсэн байна | Суурин газрын агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг 18 сум 5 тосгоны хэмжээнд зохион байгуулж дүн мэдээг БОУАӨЯаманд заасан хугацаанд нь хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулж "Хангалттай" үнэлэгдсэн. Нэгдсэн дүнгээс харахад айл өрхийн ердийн галлагаатай 3-15 кВт зуухны тоо өмнөх оноос буурсан боловч нүүрс, модны хэрэглээ өмнөх онтой ижил, 15-100 кВт зуух | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | буюу аж ахуйн нэгжийн зуухны тоо буурч, усан халаалтын 100-4200 кВт уурын зуухны тоо нэмэгдсэн байна. | | |
| 193 | 3.3.3.2.6. Чингис хотын агаарын чанарыг тодорхойлох автомат станц суурилуулах | 10.0 | Тодорхойлох үзүүлэлтийн болон мэдээллийн тоо | 2 үзүүлэлтээр өдөрт 3 удаа хэмжилт хийдэг. Мэдээллийг боловсруулалт хийсний дараа нийтэд 7 хоногт 1 удаа хүргэдэг. | Хоногт 24 удаа 5 үзүүлэлтээр хэмжилт хийж иргэдэд цаг тутам мэдээллийг хүргэнэ. | БНСУ-ын тусламжтайгаар 689,9 сая төгрөгийн өртөг бүхий автомат станцыг суурилуулж, минут тутам агаарын чанарыг 5 үзүүлэлтээр хэмжиж мэдээллийн санд нэгтгэх ажлын туршилт зүгшрүүлэлт хийгдэж байна. Мэдээллийн сангийн хэрэглэгчдэд үйлчлэх хэсэг хөгжүүлэлтийн шатанд ажиллаж байгаа ба 2026 оны 1 дүгээр улиралд нийтэд мэдээлнэ. 2025 оны 8 дугаар сараас эхлэн 5 үзүүлэлт /SO2, NO2, PM2.5, PM10, SO4/-ээр цаг тутам хэмжилт хийж мэдээллийг нэгдсэн серверт хүргүүлсэн. Сард 720-744 удаа хэмжилт хийж хэмжилтийн давтамж 3 дахин нэмэгдсэн. Туршилтын хугацаанд цахилгааны тасалдал болон стандарт хий, шүүлтүүрийн хангалтын улмаас нийт 5768 цаг ажиллаж 346,080 мэдээ цуглуулахаас 214596 мэдээ цугларч 131,484 удаагийн буюу 219 цагийн мэдээ тасарсан. | 100 | 100.00 |
| **3.3.4. Усны дахин ашиглалт, усан хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг хамгаална.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.3.4.1. Усны нөөцийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.** | | | | | | | | |
| 247 | 4.4.2.3.1 Аймгийн төвд үүрэн холбооны 5G технологийг нэвтрүүлэх, сумдын алслагдсан багуудад үүрэн холбооны сүлжээ оруулна. | 2,047.29 | сүлжээ орсон багийн тоо | 2 сумын 4 байршилд Мобикомын 3G сүлжээний сайтыг барьж ашиглалтад оруулсан | 8 байршилд үүрэн холбооны сүлжээ орсон байна. | 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үүрэн холбооны сүлжээ /Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх/ 8 суманд байгуулах ажлын гүйцэтгэгчээр "Юнител" ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 75 хувьтай үргэлжилж байна. 2026 оны 07 дугаар сард ажил дуусгах гэрээтэй. Үлдэгдэл санхүүжилт 2026 оны улсын төсөвт тусгагдаж батлагдсан. | 100 | 0.00 |
| ЗОРИЛГО 4.5 СТАНДАРТ | | | | | | | | |
| 4.5.1. Хүн амын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах орчин нөхцөлийг сайжруулна. | | | | | | | | |
| 4.5.1.1. Зүүн бүсийн хөгжлийн Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд тандалт судалгаа, шинжилгээ хийх хүнсний сорилтын лабораторийг шинэчилнэ. | | | | | | | | |
| 248 | 4.5.1.1.1. Лабораторийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 30,0 | Тоног төхөөрөмжийн тоо | Шинээр хийх | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна | Лабораторид мах махан бүтээгдэхүүнд нитрат, ундны усанд төмөр фтор нитрит, нитрат, сульфат, аммони тодорхойлох **Спектрофотометр** - 6,313,500 төгрөг , шинжилгээний явцад гарсан химийн бодисын хий уурыг зайлуулах үүрэгтэй **Татах шүүгээ** 6,900,000 төгрөг, нян судлалын шинжилгээнд тэжээлт орчин шил савыг даралтат уураар ариутгах халдваржуулах | Х/Б | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулалттай 6,900,000 төгрөг, нийт 3 төрлийн багажийг **20,113,500** төгрөгөөр Стандарт хэмжил зүйн газраас авч лабораторийн тоног төхөөрөмжийн чадавхыг нэмэгдүүлсэн. Мөн Сорилтын лаборатори нь хортон шавьж тодорхойлох **PXS микроскопыг** хандиваар, Пестицидийн үлдэгдэл тодорхойлох **HM-SP06** багажийг ХХААГ-аас ашиглалтын гэрээгээр тус тус хүлээн авч, шинжилгээний чадавх, хүчин чадлаа нэмэгдүүлээд байна. | | |
| ЗОРИЛГО 4.6 ГАДААД БОДЛОГО | | | | | | | | |
| 4.6.1. ОХУ, БНХАУ болон гуравдагч орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | | | | |
| 4.6.1.1. ОХУ болон БНХАУ-ын хамтын ажиллагаатай муж, хотуудтай хамтын ажиллагааг сэргээн эрчимжүүлнэ. | | | | | | | | |
| 249 | 4.6.1.1.1.ОХУ болон БНХАУ-ын муж, хотуудтай хамтран ажиллах салбарын тоог нэмэгдүүлэх | | Хамтарсан салбарын тоо | 2 (Боловсрол, эрүүл мэнд) | 1 | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйрийн их сургуульд 10 хүнийг Хятад хэлний сургалтад хамруулж байна. БНСУ-ын Жолла мужийн Жионжү хотын Хюсаранг эмнэлэгт 6 хүн, Кёнсаннамду мужийн Чангвон хотод “MAMF2025” арга хэмжээнд 26 хүний бүрэлдэхүүнтэй, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хоттой 12 хүний бүрэлдэхүүн, тайлант хугацаанд нийт 44 албан хаагчид гадаад улсад туршлага судлан ажилласан. 2025.09.25-нд БНХАУ-ын Шаньси мужийн Тайюань | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хотод зохион байгуулагдсан “Тайюань эрчим хүчний форум”-д оролцож арга хэмжээний нээлтэд Засаг дарга “Нүүрстөрөгчийн ялгарал багатай, байгаль орчинд ээлтэй эрчим хүчний шинэ системийг бий болгох – өөрчлөлт ба хөгжил” сэдвээр илтгэл тавьж, МУ-ын эрчим хүчний өнөөгийн байдал, бодлого, эрх зүйн орчин болон хөрөнгө оруулалтын боломжийн талаар танилцуулсан.<br>2025.08.25-нд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод зохион байгуулагдсан "Монгол - Хятад V экспо" арга хэмжээнд оролцсон.<br>БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймагтай найрсаг харилцаа хамтын ажиллагааны протоколыг эдийн засаг, худалдаа, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, экологи, боловсрол зэрэг салбарт хамтын ажиллагааг дэмжих, харилцан ашигтай хөгжилд хүргэхээр байгуулсан.<br>ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар нутгийн Амбан захирагч А.М.Осиповын урилгаар аймгийн 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл 2025.05.11-ны өдөр тус мужид очиж хамтын ажиллагааны талаар санал солилцож Аугаа эх орны | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дайны ялалтын 80 жилийн ойн баярын арга хэмжээнд оролцсон.<br>ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар нутгийн Засгийн газрын дэд дарга Б.Б.Батомункуевын урилгаар 5 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөл 2025.09.02-ны өдөр тус мужид зохион байгуулагдсан Аугаа эх орны дайны ялалтын 80 жилийн ойд зориулсан арга хэмжээнд оролцсон. | | |
| 4.6.1.2. Гуравдагч орны ижил түвшний Засаг захиргааны нэгжтэй ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 250 | 4.6.1.2.1.Гуравдагч орны муж, хотуудыг судлан хамтын ажиллагааг эхлүүлэх санал тавих | | Тавьсан саналын тоо | | 1 | Аймгийн Засаг дарга БНСУ-ын Жолла мужийн Жионжү хотын Хюсаранг эмнэлгийн Гадаад харилцааны албаны дарга Ким Жон Воныг Хэнтий аймаг хүлээн авч уулзалт хийсэн ба цаашид тус мужтай болон эмнэлэгтэй эрүүл мэндийн чиглэлээр хамтарч ажиллахаар хамтын ажиллагааг эхлүүлсэн.<br>Аймгийн Засаг дарга БНСУ-ын Чёорвон аймгийн төлөөллийг 2025. 06.14-нд Хэнтий аймагт хүлээн авч цаашид байгаль орчин, аялал жуулчлал, тэр дундаа тогоруу хамгаалах чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцож хамтын ажиллагааг эхлүүлсэн.<br>БНСУ-ын Сөүл хотод 2025.10.28-ны өдөр Хэнтий аймгийг сурталчлах | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдөрлөгийг зохион байгуулсан. Уг өдөрлөгийн үеэр БНСУ-ын хамтын ажиллагаатай муж, хотууд болон тус улсад ажиллаж амьдарч байгаа Монголчуудтай уулзалт хийсэн. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойн хүрээнд Чангвон хотод зохион байгуулагдсан "Олон үндэстний түүх, соёл, урлагийн фестиваль – MAMF2025" арга хэмжээнд Кёнсаннамду мужийн урилгаар оролцож, Монгол Улсын соёл, урлаг, өв уламжлал, ёс заншил, үндэсний спортыг сурталчлан таниулан оролцсон. | | |
| 4.6.1.3. Олон улсын болон Нэгдсэн Үндэстний Байгууллага, бүс нутгийн түвшний хамтын ажиллагааг улсын гадаад бодлогоор хэрэгжүүлнэ. | | | | | | | | |
| 251 | 4.6.1.3.1.Улсын гадаад бодлоготой уялдуулан Олон Улсын байгууллагатай хамтран ажиллах | | Хамтын ажиллагааны тоо | | 2 | Австралийн Элчин сайдын яам болон Австралийн Засгийн газрын хэрэгжүүлэгч "Australian awards" тэтгэлэгт хөтөлбөртэй хамтран Хэнтий аймагт тэтгэлэгт хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх уулзалтыг 2025.08.11-нд зохион байгуулсан бөгөөд уг уулзалтад нийт 70 гаруй иргэд, төр, хувийн хэвшлийн байгууллагаас оролцсон.<br>АНУ-ын "Дезерет" Олон улсын байгууллага хамтын ажиллагааны хүрээнд нийт 2 | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төслийн 5 багц төхөөрөмжүүдийг Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөхийн нярай болон хүүхдийн тасагт 2025.08.04-ны өдөр хандивласан. | | |
| ЗОРИЛГО 4.7 ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ | | | | | | | | |
| 252 | 4.7.1.Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалт, дадлагыг зохион байгуулах | 8.0 сая | Сургалтад хамрагдсан хүний тоо | Жил бүр сургалт, дадлагыг зохион байгуулж хэвшсэн. | 110 хүн сургалтад хамрагдсан байна. | Аймгийн Засаг даргын 2025 оны А/358 дугаар захирамжийн дагуу Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хээрийн дадлага, сургалтыг 2025 оны 6 дугаар сарын 20-оос 27-ны өдрүүдэд ОБГ-тай хамтран Гамшгийн иж бүрэн сургуультай уялдуулан зохион байгуулсан. Тус сургалтад Хэрлэн, Баянхутаг, Мөрөн сумын 40 иргэн 5 нэгж техниктэй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын сургалтын төвд зохион байгуулсан. Гамшгийн иж бүрэн сургуульд ОНХ-ын томилгоот нэгж тээвэр нүүлгэн шилжүүлэх салаа, эмнэлгийн бүлэгт ажиллаж Хэрлэн сумын 1, 4 дүгээр багийн 2351 иргэнийг хээрийн байрлалд нүүлгэн шилжүүлсэн. Мөн Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн дуурайлган үзүүлэх сургалтад хамрагдсан | 100 | 100.00 |
| 253 | 4.7.2.Орон нутгийн хамгаалалтын удирдлагын | 10 сая | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | Удирдлагын байрыг | 50 хувиар нэмэгдүүлнэ. | Удирдлагын байранд ширээ, сандал, сейф, суурин компьютер, баримт бичгийн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байрыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | | | ашиглалтад оруулсан. | | самбар байршуулж, удирдлагын байранд засвар хийж, өнгө үзэмж сэргээн, дээврээс дусаал гоожиж байгааг арилгасан. | | |
| 254 | 4.7.3.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Цэрэгжлийн спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулах | 14 сая | Арга хэмжээний тоо | Жил бүр зохион байгуулж хэвшсэн. | 1 удаа | Аймгийн Засаг даргын 2025 оны а/154 дүгээр тоот захирамжийн дагуу аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж явуулсан. Тус тэмцээнд ЕБС-ийн ахлах ангийн 16-17-настай сурагчид оролцож 12 багийн нийт 150 гаруй сурагчид хамрагдаж Хэрлэн нэгдүгээр сургуулийн Ирвэс тасаг 1 дүгээр байранд, Өлзийт тосгоны ЕБС-ийн тасаг 2 дугаар байранд, Тэмүүжин цогцолбор сургуулийн сүлд тасаг 3 дугаар байранд, Биндэр сумын ЕБС-ийн тасаг 4 дүгээр байранд тус тус шалгарсан. Шагналт байранд орсон 3 тасгаас УАШ тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулж Батлан хамгаалахын сайдын А/150 дугаар тушаалын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Цэрэг спортын Дөл-2025 онд тэмцээнд 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрөөс 07-ний өдрүүдэд Зэвсэгт | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүчний сургалтын нэгдсэн төвд байрлаж тэмцээнд амжилттай оролцсон | | |
| 255 | 4.7.4.Чөлөөлөх дайны 80 жилийн ойн арга хэмжээтэй холбогдуулан хүүхэд, залуучуудын дунд цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах | 10 сая | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 3-аас доошгүй | Монгол Улсын Засгийн газрын 189 дүгээр тогтоолын дагуу "1945 оны Чөлөөлөх дайны" ялалтын 80 жилийн ойг аймгийн хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 11-13 ны өдрүүдэд Хэнтий аймагт тэмдэглэн өнгөрүүлсэн. Дэлхийн 2 дугаар дайны эхлэл, төгсгөлд Эх оронч монголчуудын ялалт өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга Ялалт дархалсан намар концерт, Батлан хамгаалахын төв архиваас ард иргэдэд Архивын үйлчилгээ, Монгол цэргийн музейн 100 гаруй үзмэр дэлгэж 400 гаруй иргэд өдөрлөгт хамрагдсан. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр аймгийн хэмжээний ЕБС–дад Эх оронч монголчууд нээлттэй хичээлийг зохион байгуулсан. | 100 | 100.00 |
| 256 | 4.7.5 Политехникийн коллеж дээр "Оюутан цэрэг"-ийн сургалтыг зохион байгуулах | 6.0 сая | Гүйцэтгэлийн хувиар | 2024 онд оюутан цэрэг хөтөлбөрт 10 оюутныг хамруулан 100 хувь хэрэгжүүлж ажилласан. | БХС-ын тушаалаар ирүүлсэн хяналтын тоог 100 хувь биелүүлж ажиллана. | Батлан хамгаалахын сайдын А/43, Монгол Улсын засгийн газрын 140, 85 дугаар тогтоолын дагуу оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутныг 03 дугаар сарын 01-ээс бүртгэж эхлэн 03 дугаар сарын 20-ны өдөр эрүүл | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн үзлэгээр хамруулж, биеийн тамирын шалгалт авч журмын дагуу 11 оюутныг элсүүлж 04 дүгээр сарын 1-ний өдрөөс 06 дугаар сарын 08-ыг хүртэл цэргийн бэлтгэл шатны сургалтыг долоо хоног бүрийн бямба, ням гаригт өдрийн 8 цагийн багтаамжтай явуулж нийт 96 цаг буюу 2 кредит хичээлийн хөтөлбөрийг хангасан. Журмын дагуу оюутан цэргүүдийг цэргийн мэргэжлийн бэлтгэл шатны сургалтад хамруулахын өмнө эрүүл мэндийн давтан үзлэгт хамруулахад нэг оюутан зүрхний томролтой гэх оношоор хасагдаж Зэвсэгт хүчний 327 дугаар ангид 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 10 оюутан цэргийг хүргэн өгч 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Цэргийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд Цэргийн штабын дарга оролцсон. Оюутан цэргийн албаа амжилттай хаасан 10 оюутан цэргийг 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэсэн | | |
| 257 | 4.7.6. Зэвсэгт хүчний 232 дугаар ангид алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах | 10 сая | Тоног төхөөрөмжийн тоо | - | 3-аас доошгүй | ЗХ-ний 232 дугаар ангид алба хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдын мэдлэг боловсролоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж АЗДТГ-аас иж бүрэн | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3 компьютер, өнгөт принтерийн хамт гардуулан өгч дэмжлэг үзүүлсэн | | |
| ЗОРИЛГО 4.8 ГАМШГИЙН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДАЛ | | | | | | | | |
| 258 | 4.8.1.1. Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгийг бүх сумдад зохион байгуулж гамшигтай тэмцэх бэлэн байдлын чадавхийг нэмэгдүүлэх | 15 сая | Хувиар | Сумдын гамшигтай тэмцэх бэлэн байдлын чадавх 7.1 хувиар буурсан. | Сумдын гамшигтай тэмцэх бэлэн байдлын чадавх өмнөх оноос 5 хувиар дээшилсэн байна. | Аймгийн Засаг даргын 2025 оны А/136 дугаар захирамжаар Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг"-ийг Байгаль орчны газартай хамтран 03 дугаар сарын 21-ний өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 18 сум 4 тосгонд зохион байгуулж ажилласан. Аймгийн хэмжээнд сумд болон тосгодууд гамшгаас хамгаалах бэлэн байдлыг 84,8 хувиар хангасан ба өнгөрсөн онтой харьцуулбал 10,3 хувиар өссөн дүнтэй байна. | 100 | 100.00 |
| 259 | 4.8.1.2. Жил бүр томилгоот бүлэг ажиллуулж болзошгүй үер усны гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | 20 сая | Мэдээлэл хүргэсэн хүний тоо | 2024 онд томилгоот бүлгүүд 6 суманд ажиллаж 7325 тээврийн хэрэгсэл, 23240 иргэнд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэсэн | 7 суманд ажиллаж сэрэмжлүүлэг мэдээг 8000 гаруй тээврийн хэрэгсэл, 25000 иргэнд хүргэнэ. | Аймгийн Засаг даргын захирамжаар 20 сая төгрөгийг шийдвэрлүүлж 6 дугаар сарын 15-аас 9 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд Хэрлэн , Баян-Адарга, Баян-овоо, Дэлгэрхаан сумдад хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулах, мөн Хэрлэн сум, Цагдаагийн газар, Онцгой байдлын газрын хамтарсан "Үер усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний" удирдамжийг хэрэгжүүлэн ажиллахаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байна. | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 260 | 4.8.1.3. Гамшгаас хамгаалах Улсын иж бүрэн сургууль зохион байгуулах | 80 сая | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 1 удаа зохион байгуулсан байна. | Монгол Улсын Шадар сайдын баталсан хуваарийн дагуу 2025 оны зургаадугаар сард аймагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнд 80 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж ажилласан.Аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, хүмүүнлэгийн байгууллага, хуулийн этгээдийн удирдах бүрэлдэхүүний 600 гаруй төлөөлөл зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцсон.Иргэдийг аюулгүй бүс рүү шилжүүлэх дадлага сургуульд Хэрлэн сумын 1, 4 дүгээр багийн 1200 орчим иргэд оролцсон юм. Иж бүрэн сургуулийн хүрээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, зарлан мэдээлэл, нүүлгэн шилжүүлэлт, аврах ажиллагаа, хор уршгийг арилгах, сэргээн босгох үе шатны бодит дадлагуудыг газар дээр нь зохион байгуулж, оролцогчдын мэдлэг ур чадвар, хамтын ажиллагааг 90,83 хувьтай буюу ХАНГАЛТТАЙ дүгнэгдсэн. | 100 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын 2025 оны А/499 дүгээр захирамж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/412 дугаар тушаалаар "Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах заавар"-ын дагуу "Галшар" суманд гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Биндэр, Өмнөдэлгэр, Баян-Овоо сумдад гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг тус тус зохион байгуулж ажилласан. | | |
| 261 | 4.8.1.4 Орон нутгийн хэмжээнд хавар намрын улиралд ой, хээрийн гал түймрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх шуурхай бүлэг томилон ажиллуулах | 40.4 сая | Хохирлын хувь | Ой хээрийн гал түймрийн хохирол 30 хувиар буурсан. | Ой хээрийн гал түймрийн хохирлыг 40 хувиар бууруулна. | Улсын Онцгой комиссын даргын 2025 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд аймгийн Засаг даргын 01 албан даалгавар гарган гамшгийн эрсдэлийн сангаас **40.4 сая** төгрөгийг шийдвэрлүүлж түймрийн эрсдэл бүхий сумдад урьдчилан сэргийлэх **5** бүлгийн хавар, намрын улиралд ажиллуулж гарсан гал түймрийг богино хугацаанд хохирол багатай цомхотгон дарж ажилласан | 90 | 100.00 |
| 262 | 4.8.1.5 Урьдчилан сэргийлэх арга хэмжээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, | 5.0 сая | Хувиар | Гамшгийн голомтоос ард иргэдэд хүргэх | Ард иргэд гамшиг ослын талаар хүргэх | ОБЕГ болон харилцаа холбооны зохицуулах хорооны хамтарсан ажлын | 90 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гамшгийн голомтоос холбоо зохион байгуулалтын арга хэмжээг сайжруулан ажиллах | | | холбоо зохион байгуулалтыг 17 хувиар сайжруулсан. | холбоо зохион байгуулалт 20 хувиар дээшилнэ. | хэсэг тус газрын ГТУА-х 32, 42, 49 дүгээр ангиудын холбооны техник хэрэгслүүдэд засвар үйлчилгээ хийж бэлтгэл бэлэн байдлыг ханган ажилласан.<br>Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх PIN олон улсын төслөөс олгосон EcoFlow E980 1ш, нарны хавтан 100ватт-1ш, QYT KT-980Plus машины радио станц-2, гар станц-22, Хөдөлгөөнт старлинк-1 нийт 26 техник, тоног төхөөрөмжөөр тус газрын холбооны техник хэрэгслийг нэмэгдүүлж гамшгийн голомтод холбоо зохион байгуулах чадавхыг 45% нэмэгдүүлсэн. Мөн ард иргэдэд зарлан мэдээлэл хүргэх зорилгоор зөөврийн чанга яригч төхөөрөмжийг “Total music” дэлгүүрээс 5 сая төгрөгөөр худалдан авч зарлан мэдээлэл дамжуулах чадавхыг дээшлүүлж ажилласан. | | |
| 263 | 4.8.1.6. Болзошгүй гамшиг ослын үед иргэн, хуулийн этгээдийг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх харилцан ажиллах дадлага чадварыг олгох | 14 сая | Иргэн, хуулийн этгээдийн тоо | Гамшиг ослын мэдээг 12 удаагийн давтамжтайгаар 60.200 иргэнд хүргэсэн. | Гамшиг ослын мэдээг 12 удаагийн давтамжтайгаар 65000 иргэнд хүргэнэ. | “Сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэх цахим программ”-ыг өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж:<br>2024 онд – 13 удаагийн сэрэмжлүүлгийг 60.2 мянган иргэнд,<br>2025 онд – 19 удаагийн сэрэмжлүүлгийг 21 удаагийн давтамжтай багц мессежээр | 90 | 100.00 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 171,617 иргэнд хүргэж, 14.0 сая төгрөгийн зардлаар иргэдэд мэдээллийг цаг алдалгүй дамжуулсан.<br>Үзүүлэлт өссөн байдал: Сэрэмжлүүлгийн тоо: 61.5% өссөн<br>Иргэдэд хүргэсэн багц мессеж: 185% өссөн<br>Эрсдэл өндөр сумдад “Сайн дурын хэсэг” байгуулах ажлыг ""Ногоон ой-Эрсдэлгүй орчин” НҮТББ-тай хамтран Батширээт, Биндэр, Дадал, Дэлгэрхаан, Норовлин сумдад Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А114, А115 тоот захирамжаар “Сайн дурын хэсэг"-ийг байгуулж, ой хээрийн түймэр унтраах багаж хэрэгслийг олгох, сургаж дадлагажуулах ажлыг ГЭБОНЗ-ийн 40 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэлээ. People in Need “ПИН” Олон улсын төрийн бус байгууллагын санхүүжилтээр Хэнтий аймгийн 4 сумдад “Ой хээрийн түймрийн эрт арга хэмжээ” төслийг хамтран хэрэгжүүлж, 80 хүнд зохион байгуулж, 1200 өрхийн эрсдэлийн үнэлгээг хийж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас хэрэгжүүлж буй ойн ангиудын мэргэжилтэн, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгаль орчны улсын хяналтын байцаагч, байгаль хамгаалагч, ойн нөхөрлөлийн 18 сум, 5 тосгонд нийт 14 удаагийн сургалтаар 354 иргэнд танхимын болон хээрийн дадлага зохион байгуулав. | | |
| **ХОЁРДУГААР ХЭСЭГ: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | |
| **ЗОРИЛТ 2.1. АЗДТГ-ЫН ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАХ** | | | | | | | | |
| 264 | 2.1.1 Ажлын байрны соёл–5С стандартыг баримталж ажиллах | | Хэрэгжилтийн үр дүнгээр | Өрөө тасалгааг засварлаж, 5с стандартыг хэрэгжүүлсэн. | Өрөө тасалгаа, ширээний эмх цэгц сайжирсан байна. | Мэргэжилтнүүд ажлын байрны соёл–5С стандартыг өдөр тутамдаа мөрдлөг болгон өрөө тасалгаа, ширээний эмх цэгцийг сайжруулан ажиллаж байна. | 100 | 100 |
| 265 | 2.1.2 Сургалтын журмын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | "Нэг цаг нэмэх цэнэг" цахим сургалт нь 12 сэдвээр хичээл орсон бөгөөд албан хаагчдаас түвшин тогтоох шалгалтыг хагс жил, жилийн эцсээр зохион байгуулан ажилласан. | 100 | 100 |
| 266 | 2.1.3 Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөрийн дагуу байгууллагад шинээр орсон албан хаагчдад байгууллагын дотоод журам болон холбогдох дүрэм, журам заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна. | 70 | 0 |
| 267 | 2.1.4 Баримт бичиг боловсруулах, бүртгэл хяналтын журмын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Баримт бичиг боловсруулах, бүртгэл хяналтын журмын хэрэгжилтийг хангаан 332 хадгаламжийн нэгж буюу 74000 гаруй хуудас баримтыг дугаарлаж архивд байршуулсан. Улсын үзлэгт бэлдэж өрөөний тохижилтыг янзалж, устгах 670 | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хадгаламжийн нэгжийг зөөвөрлөж устгаж, цэвэрлэгээ үйлчилгээг 7 хоног бүр хийлгэж, архивын өрөөнд лац хийлгэсэн. | | |
| 268 | 2.1.5 Гэрээний бүртгэл хөтлөх | | Хэрэгжилтээр | - | Хэрэгжилтийг хангасан байна | Жилийн эцсийн байдлаар 37 гэрээ бүртгээд байна. | 100 | 100 |
| 269 | 2.1.6 Гэрээний журмын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Батлагдсан журмын хүрээнд Хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100 | 100 |
| 270 | 2.1.7 Үл тохирол бүртгэл, хяналтын журмын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/12 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Үл тохирол бүртгэл, хяналтын журам" -ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тус бүртгэлд жилийн эцсийн байдлаар үл тохирол бүртгэгдээгүй байна. | 100 | 100 |
| 271 | 2.1.8 "Байгууллагын дотоод журам"-ын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Албан хаагчдын 2024 оны ээлжийн амралтыг саналыг албан хаагчдаас авч нэгтгэн, АЗДТГ-ын даргын 2025.02.03-ны өдрийн Б/26 дугаар тушаалаар хуваарийг батлуулсан. Аймгийн ЗДТГ-ын 1 албан хаагчид нэг сарын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал, 9 албан хаагчид зэрэг дэв олгуулах асуудлаар санал гарган шийдвэрлүүлсэн. Албан хаагчдын 160 хүүхдүүдэд хүүхдийн баярын бэлэг, 10 албан хаагчийн 12- | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | р анги төгсөж байгаа хүүхдүүдэд буцалтгүй тусламж олгох саналыг оруулж шийдвэрлүүлсэн. Байгууллагын 45 ахмадуудад 3 удаагийн буцалтгүй тусламжаар 25,877,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг оруулж шийдвэрлүүлсэн. Байгууллагын 6 албан хаагчид 2,6350,000 төгрөг, 60л шатахууны буцалтгүй тусламж олгох асуудлаар санал оруулж шийдвэрлүүлсэн. Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 14 албан хаагчид 9,660,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 3 албан хаагчид шинэ хүүхэд төрсөн 300,000, шинээр гэр бүл болж байгаа 2 албан хаагчид 500,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх саналыг оруулж шийдвэрлүүлсэн. | | |
| 272 | 2.1.9 “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжилтийг хангах, зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Албан хаагчийн амьдрах орчин сайжруулахад 8 албан хаагчид 40 сая, эрүүл мэнд, ар гэрт гарсан гачигдал, бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 35.000.0 сая төгрөгийн зардлыг зарцуулсан. Түлээ нүүрсний хөнгөлөлтөд нийт 37 албан хаагчдад 5,550,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. | 90 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 273 | 2.1.10 Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Аймгийн ЗДТГ-ын хүний нөөц болон дотогшоо чиглэсэн үйл ажиллагаа хэвийн бөгөөд хэрэгжилтийг 80 хувьтай хангаж ажилласан байна. | 70 | 80 |
| 274 | 2.1.11 Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа авах журмын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй. | * | 0 |
| 275 | 2.1.12 Удирдлагын дүн шинжилгээ хийх журмын хэрэгжилтийг хангаж ажиллах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Удирдлагын зөвлөлийн хурал, байгууллагын дарга нарын шуурхай хурлын бүртгэлийг хөтөлж, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж ажилласан. Мөн Удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн-2025 арга хэмжээг зохион байгуулж 18 сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, Нарийн бичгийн дарга , Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар болон аймгийн Агентлаг, Байгууллагын 160 гаруй удирдах ажилтнууд оролцсон. | 100 | 100 |
| 276 | 2.1.13 Дотоод аудит хийх журмын хэрэгжилтийг хангах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй. | * | 0 |
| 277 | 2.1.14 Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | АЗДТГ-ын даргын А/44 дүгээр тушаалаар Мэдээллийн аюулгүй байдлын журмыг шинэчлэн баталсан. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах нийтлэг журам мөрдүүлэх | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухай аймгийн Засаг даргын 2025.06.09-ний өдрийн А/336 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | |
| ЗОРИЛТ 2.2 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ | | | | | | | | |
| 278 | 2.2.1 Аймгийн албан ёсны вэб сайт www.khentii.mn–д тухай бүр шинэ мэдээ мэдээллийг шинэчлэх | - | Мэдээллийн тоо | - | Мэдээллийг тухай бүрт нийтэлж, 7 хоног бүрийн шуурхай хуралдаанд нийтлэгдсэн мэдээллийн тоог танилцуулсан байна. | www.khentii.mn–д тухай бүр шинэ мэдээ мэдээллийг 2000 гаруй мэдээллийг шинэчилсэн. | 100 | 100 |
| 279 | 2.2.2 “Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар” цахим хуудаст орсон мэдээллийг албан хаагч бүр олон нийтэд түгээх /like, share/ | - | Хандалтын тоо | - | Хандалтын тоо нэмэгдсэн байна. | Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар пэйж хуудсанд тавигдсан мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх зорилгоор тухай бүр лайк, шейр хийж, хандалтын тоог нэмэгдүүлсэн. | 100 | 100 |
| ЗОРИЛТ 2.3. ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ | | | | | | | | |
| 280 | 2.3.1. Иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж хариу өгөх, мэдээллийг 7 хоног бүрийн шуурхай хуралдаанд нэгтгэн танилцуулах | - | Хариуг хугацаанд нь өгч шийдвэрлэсэн эсэх өргөдлийн тоо | | Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдол хугацаандаа шийдвэрлэгдсэн байна. | Аймгийн хэмжээнд 1378 өргөдөл санал хүсэлт ирж шийдвэрлэж хариу өгсөн 1352, хугацаа болоогүй, шинээр ирсэн 26, шийдвэрлэлт 98.1 хувьтай байна. Тайланг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хуулийн хугацаанд хугацаа хожимдуулаагүй 4 удаа хүргүүлсэн. | 100 | 98 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 281 | 2.3.2 Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журмын хэрэгжилтийг хангах | | Хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилтийг хангасан байна | Өргөдөл гомдол санал хүсэлтийг 21 иргэнээс хүлээн авч, мэдээллийг 7 хоног тутамд гаргасан. Засгийн газрын 1111 төвөөс хуваарилагдан ирсэн 55 өргөдлийг хүлээн авч шийдвэрлүүлсэн. Шийдвэрлэлт 95.1 хувьтай байна. | 100 | 100 |
| **ГУРАВДУГААР ХЭСЭГ: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | |
| ЗОРИЛГО 3.1. БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ | | | | | | | | |
| 282 | 3.1.1 Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн захиргааны байгууллага, иргэд, хуулийн этгээд, цэргийн насны залуучуудад сурталчлах; | 5.0 сая | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 2024 онд 8 арга хэмжээг зохион байгуулсан. | Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр 8 арга хэмжээг зохион байгуулсан байна. | Аймгийн 18 сум 4 тосгоны Тамгын газарт Батлан хамгаалах Зэвсэгт хүчний чиглэлээр гарч байгаа мэдээ, мэдээллийг цаг алдалгүй иргэдэд хүргэх зорилготой эрх зүйн цахим хөтөчтэй самбар байршуулсан. Батлан хамгаалах бодлого, зорилтыг сурталчлах ажлын хүрээнд “Эх орончч монгол Их сэргэлт”-жилийн нээлтийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга нартай Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах чиглэлээр 2 цагийн сургалтыг зохион байгуулан ажилласан. Хүүхэд залуучуудад цэрэг эх орончч үзэл олгох зорилгоор Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж буй Политехникийн коллежийн 200 гаруй сурагчдад Батлан хамгаалах | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодлого, үйл ажиллагааны талаар 2 цагийн хугацаатай мэдээлэл хийж, хүүхдүүдийн дунд хийн бууны буудлагын тэмцээнийг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Эх оронч үзэл-үндэсний бахархал” сэдэвт эссэ бичлэгийг уралдааныг 2025 оны 05 дугаар сарын 1-ний өдрөөс 06 дугаар сарын 1-ний өдрүүдэд 2 үе шаттай зохион байгуулж тэргүүний байранд шалгарсан сурагчдын эсээг олон нийтэд сурталчлан ажилласан.<br>Монгол Улсын Засгийн газрын 189 дүгээр тогтоолын дагуу “1945 оны Чөлөөлөх дайны” ялалтын 80 жилийн ойг аймгийн хэмжээг 2025 оны 08 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлсэн. Аймгийн иргэд, хүүхэд залуучуудад 2025 оны 8 дугаар сарын 11-ээс 13-ны өдрүүдэд Монгол цэргийн музейн 100 гаруй нүүдлийн үзэсгэлэн дэлгэж, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын “Ялалт дархалсан намар” бүрэн хэмжээний тоглолтыг зохион байгуулсан. Мөн Батлан хамгаалахын төв архив болон Цэргийн штабаас 20 гаруй иргэдэд архивын болон цэргийн үүрэгтний | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэмлэх олгох үйлчилгээ үзүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс болон Боловсролын газартай хамтран “Эх оронч Монголчууд” нэлттэй хичээлийг 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулж тус хичээлд ерөнхий боловсролын 28 сургуулийн 6-12 дугаар ангийн 3006 сурагчид хамрагдсан. Нийт 8 арга хэмжээг зохион байгуулж ажилласан. | | |
| 283 | 3.1.2 Багийн Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулах | 2.0 сая | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2024 онд цэргийн бэлтгэл сургалт 2 арга хэмжээ зохион байгуулсан. | Багийн Засаг дарга нарт цэргийн бэлтгэл сургалтын чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулна. | Аймгийн Засаг даргын А/587 дугаар захирамжийн дагуу Багийн Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 29-ээс 31-ний өдрүүдэд зохион байгуулсан. Аймгийн 89 багийн Засаг дарга нарт Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Батлан хамгаалахын багц хуулийн танилцуулга болон Цэргийн бүртгэл явуулах журам, Төрийн нууцын хадгалалт хамгаалалт гэсэн сэдвийн хүрээнд 2 удаагийн нийт 16 цагийн бэлтгэл сургалтыг зохион байгуулсан. | 100 | 100 |
| 284 | 3.1.3 Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт байрлах тусгай хэрэгцээний газарт “Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, | - | Холбогдох хууль тогтоомжийг судлах | ЗХЖШ-ын н/43-р албан бичиг ирүүлснийг аймгийн удирдлагад | Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж дэмжлэг | Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын ЗДТГ-тай хамтран ажиллаж 2025 онд Зэвсэг хүчний 232 дугаар ангийн тусгай хэрэгцээнд зориулж | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | салбарын тусгай хэрэгцээний газарт хориотой бүс тогтоох журам"-ыг мөрдөж ажиллах; | | | танилцуулан, аймгийн ИТХ-ын 16-р хурлаар хэлэлцүүлж 06-р тогтоолоор хүргүүлсэн. | үзүүлж ажиллах. | буудлагын талбайн ойролцоо марш тактикийн саадын зурвас байгуулах 5 км$^2$ газрыг асуудлыг шийдвэрлүүлсэн.. | | |
| 285 | 3.1.4 Зэвсэгт хүчний 104 жилийн ой, чөлөөлөх дайны 80 жилийн ойн баярын арга хэмжээг тусгай төлөвлөгөөгөөр зохион байгуулах, дайнд оролцсон ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх тэдний ар гэрт буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэх | 8.0 сая | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2024 онд ойн тэмдэглэн өнгөрүүлэх 9 арга хэмжээг хэрэгжүүлсэн | Ойн арга хэмжээтэй холбоотой 9 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Аймгийн Засаг даргын 2025 оны А/63 дугаар захирамжийн дагуу Монгол улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэлээр 8 төрлийн арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Цэргийн штабаас 3 дугаар сарыг Зэвсэгт хүчнийг сурталчлах сар болгон зарласантай холбогдуулж аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг иргэд, хүүхэд, залуучуудад сурталчлах зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 189 дүгээр тогтоолын дагуу "1945 оны Чөлөөлөх дайны" ялалтын 80 жилийн ойг аймгийн хэмжээг 2025 оны 08 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлсэн. | 100 | 100 |
| 286 | 3.1.5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын ажилтны | - | Зохион байгуулсан | 2024 онд Албан хаагчдын нийгмийн | Албан хаагчдын нийгмийн | Аймгийн ЗДТГ-ын дотоод журмын дагуу Цэргийн штабын офицеруудыг 05, 11 | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах | | арга хэмжээний тоо | асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 4 арга хэмжээг зохион байгуулсан. | асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 4 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | сард эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт БНХАУ-ын Хөх хотын төв эмнэлэгт нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, шинжилгээнд хамруулсан. Бие бүрэлдэхүүний ажиллах орчныг сайжруулан албаны өрөөнд бүрэн засвар хийж халаалтын системийг сольсон. | | |
| 287 | 3.1.6. Цэргээс халагдаж буй залуусыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулж ажлын байранд зуучлах ажлыг аймаг, сумын хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээ хувь | 2024 онд Хугацаат цэргийн албанаас халагдсан дайчидтай холбоотой арга хэмжээ 90 хувь үнэлэгдсэн. | Хугацаат цэргийн албанаас халагдсан дайчидтай холбоотой арга хэмжээ 95 хувьд хүргэсэн байна. | Хэрлэн сумын ЗДТГ, Хөдөлмөр халамж үйлчилгээний газруудтай хамтран хугацаат цэргийн албанаас 2025 онд халагдан ирсэн 200 гаруй залууст хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мөн сумдад шаардлагатай байгаа сул орон тоо ажлын байрыг сурталчлан танилцуулах ажлыг зохион байгуулсан.<br>Хугацаат цэргийн албанаас халагдан цаашид төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудад ажиллах сонирхолтой залуусыг бүртгэн ажлын байранд зуучлан өгөх арга хэмжээг зохион байгуулсны үр дүнд Өмнөдэлгэр суманд 2, Дадал суманд 1, Бор-Өндөр суманд 5, Хэрлэн суманд 10 нийт 18 иргэнийг 100 хувь тохирох мэргэжлийн дагуу ажлын байраар хангасан. | 100 | 100 |
| 288 | 3.1.7. Дайчилгааны бэлтгэл нөөцийн | БХЯ-ны төсөв | 2 удаа сургалтыг | 2024 онд цэргийн | Цэргийн бэлтгэл | Цэргийн штабын дайчилгааны нөөц, бэлтгэл | 100 | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрэлдэхүүнтэй сургалтыг зохион байгуулах; | | зохион байгуулна. | бэлтгэл үүрэгтний сургалтыг 100 хувь хэрэгжүүлсэн | албаны сургалтыг 100 хувь хэрэгжүүлсэн байна. | офицерын бүрэлдэхүүнийг үе шаттай нэмэгдүүлэх, сургаж бэлтгэх ажлын хүрээнд бэлтгэл офицерийн дамжаанд 2 иргэнийг хамруулсан. | | |
| 289 | 3.1.8. Зүүн бүсийн аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг зохион байгуулах | 30 сая | Зохион байгуулсан арга хэмжээг тоогоор | 2024 онд арга хэмжээ зохион байгуулаагүй | 1 арга хэмжээг зохион байгуулна. | Аймгийн Засаг даргын А/469 дүгээр захирамжийн дагуу Зүүн бүсийн аймаг, сумдын ЗДТГ-ын дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 3-аас 5-ны өдрүүдэд Дэлгэрхаан суманд зохион байгуулсан. Сургалтын үр дүнд 1. Бүсийн хэмжээнд Батлан хамгаалах салбарын хууль, тогтоомжийг сум, орон нутагт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал, зөвлөмжийг боловсруулсан. 2. Аймаг, сумдын ЗДТГ-ын дарга, Цэргийн штабын офицерууд нийт 110 төрийн албан хаагчийн цэргийн бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлсэн. 3. Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчинд гарч буй өөрчлөлт, Батлан хамгаалах бодлого, тогтолцоо, орон нутгийн хамгаалалт, цэргийн дайчилгаа болон төрийн нууцын хууль, тогтоомжийн сэдвийн хүрээнд шинэ мэдээ, мэдээлэл өгсөн. 4. Сум, орон нутагт батлан хамгаалах чиглэлээр | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлж буй ажлын туршлага солилцсон. | | |
| 290 | 3.1.9. “Дайчилгааны даалгавар”, “Дайчилгааны төлөвлөгөө” боловсруулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх; | - | 2003 оны Дайчилгааны төлөвлөгөө | 18 сум, 4 тосгонд Дайчилгааны төлөвлөгөө боловсруулна. | Дайчилгааны даалгавар, Дайчилгааны төлөвлөгөө боловсруулсан байна. | 2025 оны 10 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Батлан хамгаалах яамны Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газраас сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, тосгодын захирагч нарт дайчилгааны даалгавар тогтоох, төлөвлөгөө боловсруулахад хяналт тавих, үнэлгээ, хийх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Үр дүнд аймгийн-1, сумдын-18, тосгоны-4 нийт 23 дайчилгааны төлөвлөгөөг боловсруулан хянан баталгаажуулах ажил хийгдэж аймгийн Засаг даргаар батлуулахад бэлэн болсон. | 100 | 100 |
| 291 | 3.1.10. Сум бүрд Орон нутгийн хамгаалалтын сургалтын танхимыг тохижуулах ажлыг зохион байгуулах | Сумын төсөв | Зохион байгуулах арга хэмжээ тоогоор | 2024 онд сум тус бүрд орон нутгийн хамгаалалтын сургалтын 22 танхим байгуулж хэрэгжүүлсэн | 4 тосгонд орон нутгийн хамгаалалтын сургалтын танхимтай болсон байна. | Хэнтий аймгийн 18 сум, 4 тосгонд байгаа иргэний танхимыг түшиглэн орон нутгийн хамгаалалтын танхим байгуулсан.<br>Сумдын иргэд хүүхэд, залуучуудад Батлан хамгаалах салбарын хууль, тогтоомж мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, танилцуулах зорилгоор QR-кодтой мэдээллийг самбар 22 ширхэг хийж иргэний танхимд байрлуулсан. | 100 | 100 |
| 292 | 3.1.11. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бэлэн байдлыг | 5.0 сая | Зохион байгуулах арга хэмжээ тоогоор | 2024 онд Орон нутгийн хамгаалалтын | Орон нутгийн хамгаалалтын томилгоот | Аймгийн Засаг даргын 2025 оны А/358 дугаар захирамжийн дагуу Орон | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дээшлүүлэх, иргэдийг нэмж томилгоожуулах, сургалтыг зохион байгуулах; | | | томилгоот нэгжийн сургалтыг 2 удаа хэрэгжүүлсэн. | нэгжийн сургалтыг 2 удаа хэрэгжүүлсэн байна. | нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтыг 2025 оны 6 дугаар сарын 20-оос 27-ны өдрүүдэд 40 иргэн 2 нэгж техниктэй хээрийн байрлалд зохион байгуулсан. Тус сургалтын төгсгөлд 3 хоног ОНХ-ын томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүнийг "Гамшгаас хамгаалах иж бүрэн" сургуульд оролцуулан мэргэжлийн бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэн ажилласан. | | |
| 293 | 3.1.12. Орон нутгийн хамгаалалтын нөөцийг үе шаттайгаар бүрдүүлэх; | 11 сая | 4*4 майхан 2ш, дэлгэц-1ш, компьютер -1ш, самбар-10ш ) | 2024 онд Орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлэлт 60 хувьтай хэрэгжсэн. | Орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлэлт 80 хувьтай хэрэгжүүлсэн байна. | Цэргийн штабын хээрийн сургалт, бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэх орон нутгийн хамгаалалтын нөөцийг үе шаттай бүрдүүлэх зорилгоор 2025 оны жилийн эцсийн байдлаар тусгай үүрэг гүйцэтгэхэд хэрэглэгдэх цэргийн зориулалттай иж бүрэн хувцас 40, аранз 20, эвхдэг ор 10, 4*6 хэмжээтэй майхан 4, сургалтын зөөврийн дэлгэц 1, богино долгионы гар станц 10, өнгөт притер 1, дрон 1 , Чанга яригч 1 ширхгийг тус тус бүрдүүлсэн. цэргийн штабын хээрийн байрлал, болон автомашинд суурилуулан ашиглах боломжтой өндөр хурдны интернет 12в-ын /Startlink/ зөөврийн төхөөрөмж тус тус худалдан авч Орон нутгийн | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамгаалалтын нөөц бүрдүүлэлтийг 85 хувьтай хэрэгжүүлсэн. | | |
| 294 | 3.1.13. Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлэх бэлтгэлийг хангах; | 10 сая | Зохион байгуулах арга хэмжээ тоогоор | 2024 онд харилцан ажиллах төлөвлөгөөг байгуулж 2 арга хэмжээ хамтран хэрэгжүүлсэн. | Харилцан ажиллах төлөвлөгөөг байгуулж 2 арга хэмжээ хамтран хэрэгжүүлсэн байна. | 2025 онд "Батлан хамгаалах сэргэлт" арга хэмжээний хүрээнд тус ангид алба хааж байгаа дайчдын компьютерын мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/31 дугаар захирамжаар 10,000,000 төгрөгийн үнэ бүхий DELL I5 маркийн иж бүрэн компьютер 3 ширхэг, EPSON маркийн өнгөт принтер 1 ширхгийг, Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагчид Цэргийн штабын зүгээс анги байгууллагад дэмжих зорилгоор санал тавьсны дагуу ангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 9 сая төгрөгийн үнэ бүхий ухаалаг дэлгэцийн хамт гардуулан өгч дэмжлэг үзүүлсэн, 2025 оны 2 дугаар ээлжийн хугацаат цэргийн албанд татагдан албаа хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн тангараг өргөх ёслолын арга хэмжээнд аймгийн Засаг дарга оролцож тус баяраар ЗХ-ний 232 дугаар ангид Старлинк гардуулан өгсөн. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 295 | 3.1.14. Аймаг, сумын цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн цэргийн болзошгүй ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг бодитоор тооцон боловсруулж, дүгнэлт гаргах; | - | Зохион байгуулах арга хэмжээ хувь | 2024 онд аймгийн болон сумын цэрэг-стратегийн үнэлгээг 100 хувь хэрэгжүүлсэн | Аймгийн болон сумын цэрэг-стратегийн үнэлгээг 100 хувь хэрэгжүүлсэн байна. | Аймгийн нийгэм, эдийн засгийн статистикийн үзүүлэлт, Онц чухал обектуудын судалгаа, цэргийн ажиллагаанд нөлөөлөх мэдээ, мэдээлэлд тулгуурлан 2025 онд 18 сум 4 тосгоны Цэрэг стратегийн үнэлгээг боловсруулан баталгаажуулах ажил 100 хувьтай явагдсан. Нийт 23 нууц баримт бичгийг боловсруулан цэргийн штабын судалгаа, мэдээллийн санд ашиглаж байна. | 100 | 100 |
| 296 | 3.1.15. Аймгийн батлан хамгаалах газрын удирдах бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх боломжийг дээшлүүлэх талаар ажлыг зохион байгуулах; (удирдлагын байрыг шинээр төхөөрөмжлөх, туулах чадвар сайтай автомашин, богино радио станц, болон starlink) гэх мэт. | ОНТ | Зохион байгуулах арга хэмжээ гүйцэтгэлээр | 2024 онд 10 ширээ, 20 сандал авч холбогдох хууль тогтоомжийн сурталчлах самбарыг байршуулсан. | Батлан хамгаалах газрын даргын удирдлагын байрыг бүрэн төхөөрөмжилж дуусгасан байна. | Аймгийн Батлан хамгаалах газрын удирдлагын байрны хаалга, цонхыг шинэчлэн урсгал засвар хийж, хээрийн байрлалд ашиглах 4*4 хэмжээтэй майхан 1 ширхэг, сургалтын зөөврийн дэлгэц 1 ширхэг, Батлан хамгаалах газрын даргын удирдлагын байр болон автомашинд суурилуулан ашиглах боломжтой өндөр хурдны интернэт 12в-ын /Startlink/ зөөврийн төхөөрөмжийг байрлуулсан. Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт Цэргийн штабын сургалтын болон нөөц батлан хамгаалах газрын даргын удирдлагын байраар ашиглах боломжтой 1 өрөөг бүрэн тохижуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
